



Өгэм

2020 оны дугаар №2

ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ЕРӨНХИЙ ГАЗАР



СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР, ГАРЫН АВЛАГАТАЙ БОЛЛОО



Баривчлах төв нь Нэгдсэн үндэстний байгууллагын Хүн амын сангийн “Жендерт суурилсан х ү ч и р х и й л э л т э й тэмцэх хөтөлбөр”-ийн санхүүжилтээр гэр бүлийн хүчирхийлэл үйлдсэн этгээдийг дахин давтан зөрчил үйлдэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор Монгол Улсын Багшийн их сургуулийн Сэтгэл судлал, арга зүйн

тэнхимийн багш нарын багтай хамтран “Баривчлагдсан этгээдийн зан үйлд нөлөөлөх сэтгэл зүйн үйлчилгээний хөтөлбөр”, олон төрлийн бодит байдалд тулгуурласан кейс, бодомж, жишээ, дадлага ажил бүхий агуулгатай багшийн болон баривчлагдсан этгээдэд зориулсан сургалтын дэвтэр, Дотоод хэргийн их сургуулийн Эрдэм шинжилгээний нэгдсэн хүрээлэнгээр “Баривчлах шийтгэл оногдуулсан шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх ажиллагааны эрх зүйн зохицуулалт, хэрэгжилт, тулгамдсан асуудал” сэдэвт захиалгат судалгааны ажлыг, олон нийтийн эрх зүйн боловсролд зориулж “Баривчлах шийтгэлийн эрх зүйн зохицуулалт” гарын авлага, боршур, зурган болон текстэн ханын самбаруудыг бэлтгэн байршуулж, өдөр тутмын үйл ажиллагаандаа ашиглаж эхэллээ.



ЗӨВЛӨГӨӨ

ХЭРХЭН БҮТЭЭЛЧ УНШИГЧ БОЛОХ ВЭ ?
НОМЫН ТЭМДЭГЛЭЛ ХӨТЛӨХ
15 МИНУТАД ТАРХИА ХЭРХЭН АМРААХ ВЭ II НҮҮР

ТАНИН МЭДЭХҮЙ

УЛСЫН БАЯР НААДМЫН ТУХАЙ III НҮҮР



ХУУЛИЙН БУЛАН

НИЙГМИЙН ДААТГАЛЫН САЙН ДУРЫН ДААТГАЛЫН ТУХАЙ IV НҮҮР

ЭРҮҮЛ МЭНДИЙН ЗӨВЛӨГӨӨ

ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЦАХИМ МАШИНЫ ТУХАЙ



УРАН ЗОХИОЛ

“УТГЫН ЧИМЭГ-2019” БОГИНО ӨГҮҮЛЛЭГИЙН НААДМЫН ТЭРГҮҮН БАЙРТ ШАЛГАРСАН ӨГҮҮЛЛЭГ V НҮҮР

ХҮМҮҮЖИГЧИЙН БУЛАН VI-IX НҮҮР

СПОРТЫН БУЛАН

ДЭЛХИЙН АЛДАРТАЙ СПОРТУУДЫН ҮҮСЭЛ X НҮҮР



ТАНИН МЭДЭХҮЙН БУЛАН

УЛААНБААТАР ХОТЫН ТУХАЙ
МОНГОЛ УХААН МОНГОЛЧУУДЫН МЭНДЛЭХ ЁС XI НҮҮР



ГАГНУУР ХИЙХ ЗААВАР
АНГЛИ ХЭЛНИЙ ХИЧЭЭЛ XII НҮҮР



“Сайхан сэтгэл бэр хэзээ ч хуучирдалгүй
цорын ганц хувцас”

ЭРХЛЭГЧ:

Сургалт, нийгэм, сэтгэл зүйн хэлтсийн дарга, дэд хурандаа
Ч.Цэнгэлбаяр
Нарийн бичгийн дарга:
Мэргэжилтэн, ахмад Д.Өлзийсүрэн

Гишүүдэд:

Хорих ял элдүүлэх албаны дэд дарга
бөгөөд харуул хамгаалалт, аюулгүй
байдлын хэлтсийн дарга, дэд хурандаа
Ч.Мөнх-Эрдэнэ

МСҮТ-ийн захирал, ахмад Х.Батбаяр
Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах
төвийн эрхлэгч, хошууч Х.Баясгалан
Ахлах мэргэжилтэн хошууч Ө.Саруултуяа

Мэргэжилтэн, ахмад Н.Болормаа
Мэргэжилтэн, ахмад Ч.Дашдэлэг

ХЭРХЭН БҮТЭЭЛЧ УНШИГЧ БОЛОХ ВЭ?

НОМЫН ТЭМДЭГЛЭЛ ХЭРХЭН ХӨТЛӨХ ВЭ?



1. Ямар төрлийн номонд дуртай вэ гэдгээ тодорхойл.

Баримтат, намтарчилсан, адал явдалт, уран зохиолын, шинжлэх ухааны, түүх философийн, хувь хүний хөгжлийн гээд аль төрлөөр уншвал чиний сонирхлыг илүү татаж байгааг олж мэд. Ингэхийн тулд мэдээж төрөл төрлийн ном уншиж, туршиж үзэх хэрэгтэй.

2. Ном унших орчноо бүрдүүл.

Гэртээ өөрийн гэсэн орчныг бүрдүүлж унших нь үр дүнтэй байдаг байж болно. Тэндээ унш. Эсвэл чимээ шуугиан багатай номын санг сонгож болно.

Хаана чи тухтай, үр дүнтэй уншлага хийж байна, тэр орчинд л очих хэрэгтэй.

3. Номоо гарт ойрхон, нүдэнд үзэгдэх газраа байрлуул.

Хичээлийн ширээ, амралтын буйдан, гал тогооны тавиур, цонхны тавцан, угаалгын өрөө, зурагтын дэргэд гээд байнга хүрдэг, очдог газрууддаа байрлуулаарай.

4. Ном унших хуваарьтай бол.

Өглөө эртлэн босож багадаа 30 минутыг ном уншихад зарцуул. Бас унтахын өмнөх уншлага хийж байгаарай. Мөн ажил эхлэхээс 30 минутын өмнө очоод унших, цайны цагаар унших, бүр бууз жигнэж байхдаа унших зэргээр ч төлөвлөж болох юм. Цагийн үр дүнтэй ашиглах хэрэгтэй.

5. Хэзээ ч өөрийгөө "шахаж" болохгүй.

Ном унших нь чиний хүсэл сонирхол дээр тулгуурласан ажил байх ёстой. Чиний дурлаж хийсэн зүйл л чамд үр дүнгээ өгөхөөс биш, хийх ёстой гэж бодож хийсэн зүйл үр дүнгээ өгөхгүйг санаарай.

6. Номын тэмдэглэл хөтлө.

Үүнд уншсан номын тухай өөрийн сэтгэгдэл болон таалагдсан эшлэлүүд бичих, шинэ санаа тэмдэглэх, ирэх сард, жилд унших номын жагсаалт, авах номын жагсаалт, уншсан номын жагсаалт бичих зэрэг олон талаас нь тэмдэглэл хөтөлж болно. Эдгээрийг хэрэгжүүлэх нь уншлагаа үр дүнтэй болгох чухал арга юм шүү.

Номоо хүссэнээрээ ашигла

Унших явцад таалагдсан эшлэл, санаа зэргийг номон дээрээ тэмдэглэж байх. Тодруулагч, харандаа, өнгийн үзэг ашиглан таалагдсан, чухал хэсгийн доогуур тэмдэглэл хийгээрэй. Номоо эргэн сөхөхөд шууд л хамгийн таалагдсан бөгөөд чухал санаа өгөх үг өгүүлбэр нүдэнд тусдаг байвал номоос авах ёстой зүйлээ авч буйтай адил. Хэрэв номоо алаг эрээн болгохыг хүсдэггүй бол номын бүлэг бүрээс төрсөн санаагаа наадаг цаасан дээр тэмдэглэж дунд нь хавчуулдаг арга тустай. Аль нь байлаа ч дараа нь тэмдэглэл хөтлөх, нийтлэл бичвэр бичих, номын гол санаагаа тодорхойлоход тусалдаг юм шүү.

Эшлэл, ухаарал, шинэ санаа өгөх үг, өгүүлбэрийг тэмдэглэдэг тусгай дэвтэртэй болох

Онцгой хэсгүүдийг бичдэг зориулалтын дэвтэртэй болохыг эрмэлзээрэй. Уйдсан үедээ, шинэ санаа хайсан үедээ, ганцаардсан үедээ тэмдэглэсэнээ эргээд унших нь үр дүнтэй аргуудын нэг болдог. Нөгөө талаасаа дэвтэрт бичсэн зүйлс чиний дотоод ертөнцийг, номын үнэ цэнийг илтгэхүйц үнэт цаас болно оо гэсэн үг.

Номоо уншиж дуусангуутаа тэмдэглэл хөтлөхийг эрмэлзэх

"Ямааны мах халуун дээрээ" гэдэг дээ? Энэ арга нь номоос төрсөн мэдрэмжээ буулгаж, төрсөн санаагаа шинэ дээр нь тэмдэглэхэд тус болдог. Бичиг үсэг, утга найруулгын алдааг дараа нь засчаж болох учир эхлээд орж ирсэн үг бүрийг л буулгахыг хичээгээрэй. "Бичиж тэмдэглэх гэсээр байгаад санаа маань бараг л хуучирчихлаа дөө" гээд тэмдэглэл бичихээ хойшлуулсаар байдаг тохиолдол олон бий.


Жишээ, баримт тэмдэглэлдээ оруулах

Өөрт тохиосон бодит жишээг тэмдэглэлдээ татан оролцуулах нь тэмдэглэлийг сонирхолтой бөгөөд уншихад хялбар болгодог. Мөн тодорхой үйл явдал, бодит жишээгээр баяжуулах нь номын санаа ой тойнд буухад илүү амархан байдаг.

Бусдад биш өөртөө зориулж бичих

"Хүмүүст зориулж бичиж байна" гээд бодчихоор "бусад хүмүүс юу гэх бол" гэсэн бодолд ороогдож сүүлдээ үг ч гарахаа больчихдог тал бий. Тиймээс чи өөрөө ямар санааг тэмдэглэлээрээ илэрхийлэхийг хүсэж байна, ямар санааг буулгамаар байна, яг юуг холбож бичмээр байна зэрэг асуултад хариу өгөх байдлаар санаагаа буулгахыг эрмэлзээрэй. Чиний бичвэр чамд л хамгийн түрүүнд таалагддаг байх хэрэгтэй.

СЭТГЭЛ ЗҮЙЧ ЗӨВЛӨЖ БАЙНА 15 МИНУТАД ТАРХИА ХЭРХЭН "АМРААХ" ВЭ?



Тархи нь хүний хэрэгтэй хүчилтөрөгчийн 20%-иар тэтгэгдэж байнгын идэвхтэй ажилладаг бөгөөд хүн өдөрт 70,000 зүйлийг бодож тархиа ажиллуулдаг гэсэн судалгааны дүнд байдаг ажээ. Энэ их ачаалал дунд сөрөг муу бодлууд бидний сэтгэл зүйд нөлөөлж уур бухимдал болон хүндэрсээр стрессийг бий болгодог байна. Харин эдгээрээс өөрийгөө хэрхэн хамгаалах болон уурлаж бухимдсан үедээ энэ байдлаас хурдан ангижран, хэвийн байдалдаа эргэн орох дараах зөвлөгөөг туршаад үзээрэй. Энэ арга бол ердөө 15 минут үргэлжлэх бөгөөд маш үр дүнтэй юм шүү.

5 минутын идэвхтэй хөдөлгөөн.

Хэрвээ та байнгын суугаа ажилтай бол энэ арга танд бүрэн тохирно. Дасгал хөдөлгөөн гэдэг хүний бие махбодыг эрүүлжүүлэхээс гадна танд цоо шинэ эрч хүчийг өгдөг гэдгийг та ч мэднэ байх. Ингээд сэтгэлээ сэргээхийн тулд 5 минутын турш идэвхтэй дасгал хөдөлгөөн хийнэ. Эхлээд биеэ

халаагаад сунгалтын дасгал, сунгалт, хэвлий болон нурууны дасгалуудыг хийгээрэй.

4 минутын талархал илэрхийлээрэй.


Таны бие дасгал хийсний дараа бага зэрэг ачаалал авсан байх болно. Ингээд биеэ амраангаа дараах 4 минутыг амьдралд талархаарай. Эрүүл саруул байгаадаа, таныг хайрлах хүн байдаг, та энд бичсэн зүйлийг уншиж, бас эргэцүүлэн бодож чадаж байгаадаа талархаарай. Таны уур бухимдлыг хүргэсэн шалтгаануудыг бус харин сайн сайхан зүйл бодоорой.

3 минутын бясалгал

Дээрх 9 минутад таны бие болон сэтгэлд нэлээн эерэг өөрчлөлт гарсан байх нь дамжиггүй. Эдгээр аргууд тархиа цэвэрлэх үйл явцад суурь бэлтгэл нь болж өгөх ба дараагийн 3 минутыг бясалгалд зориулаарай. Бясалгал гэдэг нь дотоод өөрийгөө нээн, гэгээрэлд хүрэх зам билээ. Харин энэ үедээ яг юунаас болж сэтгэл санаа тань үймрээд байдаг тухай, одоо тайвширсан үедээ тэр болгон чинь ямар ч утгагүй, таны уурлах шалтаг болохооргүй өчүүхэн зүйл байсан талаар бодоорой.

2 минутын нам гүм

Одоо харин бататгалын 2 минут. Та яг одоо ажил дээрээ байгаа бол гар утас, компьютерээ унтраагаад нам гүмийг эрхэмлэн, дотоод сэтгэл зүрхээ чагна. Танд хэн ч саад



болохооргүй ганцаараа амралтын өрөөнд сууж болно.

1 минут гүнзгий амьсгал

Эдгээр дасгалын хамгийн сүүлийн 1 минутад гүнзгий амьсгаа аваарай. Амьсгалаа гаргахдаа өөрт тохиолдсон бүх муу юмс биеэс минь гараад явчихлаа хэмээн бодоорой. Харин амьсгаагаа авахдаа цоо шинэ эрч хүчээр цэнэглэгдлээ гэж өөрийгөө сэргээгээрэй.

Эх сурвалж: "Сэтгэл зүйч" сонин

ТАНИН МЭДЭХҮЙ



ҮНДЭСНИЙ ИХ БАЯР НААДМЫН ТУХАЙ

Наадам - монгол үндэстний зуны дэлгэр баяр, олон төрөлт спортын тэмцээн юм.

Монгол орны зун цаг эртнээс найр наадмын уламжлалтай байв. 13-р зууны МНТ-д бичигдсэнээр наадам "хуран сар"-д (долоодугаар сар) болдог байсныг тэмдэглэсэн.

Долоон хошуу даншиг наадам

Жил бүр тогтмол явагдах болсон нь 1639 онд Өндөр гэгээн Занабазарт зориулсан даншиг наадмаас эхэлсэн. Ширээт цагаан нуурын энэ наадамд Бөх лам барилдан түрүүлж, Бонхор донир гэгчийн морь магнайлсан нь тэмдэглэгдэн үлджээ. 1696 онд Долоннуурт том наадам болсон. 1911 онд Монгол улс тусгаар тогтноход даншиг наадмыг болиулсан

Арван засгийн наадам

1772 онд Хэнтий уулыг тахих их наадам болов. Үүнийг Арван засгийн наадам гэнэ. Алдаг оног хийдэг байсан Арван засгийн наадам 1912 оноос жил бүр хийгдэх төрийн наадам боллоо. Богд хаан нас барах хүртэл буюу 1925 он хүртэл Арван засгийн наадам төрийн наадам болов. Арван засгийн наадмыг нийт 125 удаа хийжээ.



Ардын төрийн наадам

1922 оноос Цэргийн наадам тэмдэглэх болов. Бургас цавчих зэрэг цэргийн урлаг номер үзүүлдэг тэр наадмыг Богдыг хаан ширээнд дахин залсан ба "Ардын" засаг тогтсоныг тэмдэглэж зуны тэргүүн сарын 6-нд наадахаар заасан. Тэр жилийн Цэргийн ба Арван засгийн наадамд хоюуланд нь Вандан аварга түрүүлсэн. БНМАУ тогтсны дараа хоёр наадмыг хамтруулах шийдвэр 1925 оны 5-р сарын 15-нд Засгийн газрын хуралдаанаас гарч, наадмын товыг 7-р сарын 11 гэж заажээ. Энэ үеэс "Ардын наадам" гэж байгаад Монгол улс олон улсад хүлээн зөвшөөрөгдсөнөөс буюу 1946 оноос хойш "Ардын хувсгал ялсны ой" гэж тодотгох болсон. 1951, 1961, 1971, 1981 оны наадам Ардын хувсгал ялсны тэгш ой тохиосон учир их ач холбогдол өгч тэмдэглэж байв.



Үндэсний их баяр наадам

1990 оноос хойш МАХН, АН хоёр нам наадмын тодотгол дээр сөргөлдөх болсон. 1996 оны УИХ-ын сонгуульд Ардчилсан хүчин ялснаар тэр жилийн наадам Монголын тулгар төр байгуулагдсны 790 жилийн ой гэж тэмдэглэгдэв. 2006 онд «Их Монгол улс байгуулагдсаны 800 жилийн ой» болгон тэмдэглэсэн. 2015 оны байдлаар Хүннү улс нэгдсэн оноос эхлэн наадмын тодотголыг «Тулгар төрийн 2224 жил, Их Монгол Улс байгуулагдсаны 809 жил, Ардын хувьсгалын 94 жилийн ойн Үндэсний их баяр наадам» гэдэг болсон байв.

Тэмцээн уралдаан

Бөх барилдах, морь уралдуулах, нум сум харвахыг дээр үеэс «Эрийн гурван наадам» хэмээн холбожээ. Одоо дөрвөн төрлөөр наадаг.

Бөх барилдаан

Дундговь аймгийн Өлзийт сумын Дэл хөнжлийн ууланд Монгол

ҮНДЭСНИЙ ИХ БАЯР НААДМЫН ТУХАЙ

бөхийн барилдаанаар наадам хийж байсан хадны зураг олдсон байна. Энэ зураг хүрлийн үеийн дурсгалд холбогдож байгаагаас үзэхэд 7,000- 11,000 жилийн өмнөх үед хамаарах ба хамгийн багаар бодоход 7,000 жилийн өмнө монгол бөх байсан гэсэн үг юм.

Монгол бөхийн өвөрмөц нэг зүйл нь түүний хувцас, өмсгөл юм. Монгол ардын тууль "Эрийн сайн хан харангуй"-д "буурын арьсан зодог, бухын арьсан шуудаг" гэж гарч буй нь эрт цагт зодог шуудгийг ямар нэг хүч тэнхээтэй гэгдэх амьтны арьс ширээр хийж байсныг гэрчилдэг. Барилдах бөхийн малгайг засуул нь авч нэр, алдрыг нь дуудахад тэрээр бүргэд, харцага, начин шонхор гэх мэт үлгэр домгийн шувуу хангарьдын нисэх хөдөлгөөнийг дүрслэн дэвсээр барилдах газраа очно.

Монгол бөхийн зодог нь цэнхэр байдаг нь өнгөний хувьд мөнх хөх тэнгэрийг бэлгэдэж улаан шуудаг нь Монгол бөхийн гал голомт тасрахгүй үргэлжид бадамлаж байхыг бэлгэджээ. Түүхийн



зарим үед монгол бөхийн зодог шуудаг нь шашны янз бүрийн номлол бэлгэдлийн тогтолцооны өөр өөр хэв шинжээс хамаарч харьцангуй ондоо өнгөөр хийгдэж ашиглагдаж байсан байна. 1921 оноос улаан зодог, хөх шуудгийг хэрэглэх болсон нь



хувьсгалт үзэл санааг дээдлэх үйл болон тайлбарлагдаж эрхэмлэгдэх болжээ.

Монгол бөхийн цол нь одоогийн мэдэгдэж байгаагаар ойролцоогоор 1,600-гаад жилийн түүхтэй ажээ.

11-р зууны сүүлчээс эхлэн бөхчүүдэд харцага, бүргэд, гарьд, шонхор зэрэг жигүүртэн амьтны нэрээр, 12-р зууны дунд үеэс тулгат, шандас гэдэг цол нэмэгдэн олгогдож байжээ. 13-р зууны дундаас одоогийн хэрэглэж байгаа начин заан, арслан аварга зэрэг нэрээр наадамд шөвгөрсөн бөхчүүдэд цол олгох болжээ.

2005 онд батлагдсан үндэсний баяр наадмын тухай хуулиар Улсын наадамд 5 давбал Улсын начин, 6 давбал Улсын харцага, 7 давбал Улсын заан, 8 давбал Улсын гарьд, 9 ба түүнээс дээш давбал Улсын арслан, Улсын Арслан цолтон түрүүлбэл Улсын аварга, Улсын Аварга цолтон түрүүлбэл Далай аварга, Улсын Далай Аварга цолтон түрүүлбэл Даян аварга, Улсын Даян Аварга цолтон түрүүлбэл Дархан аварга цол олгодог болсон. Мөн аймгийн наадамд 5 давбал Аймгийн начин, 6 давбал Аймгийн харцага, 7 давбал Аймгийн заан, 8 ба түүнээс дээш давбал Аймгийн арслан, Аймгийн арслан цолтон түрүүлбэл Аймгийн хурц арслан цол олгоно.

Морин уралдаан

Хүлэг морьдын дотроос хамгийн хурданыг нь сонгон авч олон хоногийн өмнөөс хоол ундыг нь тохируулан сойж, өдөр тутам давхиулан сорьж бэлтгэдэг нас, насаар нь ялган газрын хол ойрыг тохируулан уралдуулдаг. Тухайлбал их насны морьдыг барагцаалбал 22-28 км, соёолон болон азаргыг 20 км, хязгааланг 18 км, шүдлэнг 15 км, даагыг 10 км орчим газраас засаж бэлтгээгүй хээрийн замаар уралдуулна. Хурдан морь унах хүүхэд хөдөлгөөнд саад болохгүй, халууцахад бие барихгүй, давхиад салхи хөөрөгдөхгүй, биед тохирсон, хөнгөн авсаархан, тод өнгийн хувцас өмсөнө. Сүүлийн жилүүдэд мориноос унаж, бэртэхээс хамгаалсан хувцас хэрэглэл өмсдөг болсон билээ. Тохой зандан ташуурынхаа сурыг нь алдартал морио ороолгох жаахан хүүхдүүдийг наадамчин олон өхөөрдөж, сэргэлэн авхаалжтайг нь магтан ярилцана.

Хурдан морийг нас насаар нь уралдуулдаг: Үүнд

- Даага - 2 настай
- Шүдлэн - 3 настай
- Хязгаалан - 4 настай
- Соёолон - 5 настай
- Азарга - 7-оос дээш настай буюу Нас гүйцсэн
- Их нас (Бүдүүн морь) - 7-оос дээш настай буюу Нас гүйцсэн
- Жороо - сайхан явдалтай

Монгол нутгийн адуу холд тэсвэртэй бөгөөд нас насаар нь ялгаж 10-30 км газар уралдуулдаг.

Сурын харваа

Энэхүү тэмцээн нь нум сумаа улам боловсронгуй болгон аль болох хол зайд цэцэн мэргэн онох харваачийн эрдэм чадварыг дээшлүүлж, ан гөрөөнд их олз олохыг эрмэлзэх, ан авлаж, их олз олсны дараах бүжиг наадмын үед цэцэн мэргэн харваачдаа нум сум харвуулан цэнгэх заншлаас үүссэн байна.

Сур харваа буюу Монгол сур харваа нь Монголчуудын эрхий мэргэнээ сорин тэмцэлдэх наадам юм. Сур харваа нь өнөө үеийн Үндэсний их баяр наадмын дөрвөн төрлийн нэг бөгөөд буриад сур харваа, халх сур харваа, урианхай сур харваа гэх 3 төрөл байна.

"Сур харвах газрын зай нь 45 нумын буюу 75-80 метр орчим газар бөгөөд нарийн зүссэн сураар сүлжиж хийсэн бортог хэлбэрийн байнуудыг хана, хасаа гэсэн хоёр янзаар үелүүлэн өрөөд болцуут сумаар хоёр тал ээлжлэн харваж цэцэн мэргэнээ сорилцоно. Ингэхдээ хүн нэг бүрийн цуваа байдлаар, эсвэл багийн гэсэн хоёр хэлбэрээр зохих журмыг баримтлан тодорхой тооны сум харвадаг" тухай ном сударт олонтаа өгүүлэгдсэн нь бий.

XIII зууны үед гэр бүрт морин хуураас гадна нум сум байсан. Эр хүн бүр нумтай байхаас гадна эмэгтэй хүн ч гэсэн харвадаг байжээ. Монгол цэргийн түүхэнд хамгийн хол харвасан хүн бол Чингис хааны ач хүү Есүнгэний харвасан 330 алд газар бөгөөд ойролцоогоор 520 метр юм.

Халх сурын харваа нь баяр наадмын 7 сарын 10,11,12 ны өдөр болдог ба эхний өдөр 16 сум хоёр дахь өдөр 12 сум гурав дахь өдөр 12 сум нийт 40 сумны нийлбэр оноогоор дүнг гаргадаг.

Эрэгтэй 75 метр, эмэгтэй 65 метрээс, хүүхдүүд өөрийн нас хүйсээс хамаарч тогтоосон зайнаас харвана.

1.68м өргөнтэй, 2,5м урттай зурхайн арын ирмэг дээр хасаа(8*8см диаметртэй сураар сүлжсэн бай) Үг өрсөн бай байна. Эхний 20 сумыг хана суранд(60 ширхэг сураас бүрдсэн бай) дараачийн 20 сумыг хасаа суранд (30 ширхэг сураас бүрдсэн бай) нийт 40 сум харваж наадна.

Харваачдын тооноос хамаарч хэдэн ч зурхай(бай) засч болдог. Нэг зурхай дээр нэг удаа 4 харваач цолны эрэмбээр зогсож харвах ба үүнийг үе гэнэ. Үндэсний сурд цолны эрэмбээр мэргэ үе, шил мэргэ үе, ноён үе, баатар үе, хөндий үе, шувтарга мэргэ үе гэж ангилна.

Сурын харваанд шалгарсан хүмүүст мэргэн цол чимэг олгодог байв. Тухайлбал наадамд сур сайн харвасан хүмүүст маш гайхамшигт мэргэн, хичээнгүй зоригт мэргэн, улам нэмэх хурц мэргэн, нягт идэр хурц мэргэн, өрнөн дэлгэрэх идэр мэргэн, чин итгэлт хэтэрхий мэргэн зэрэг цолыг олгож байжээ. Өнөө үед сурчдын амжилтыг өөгшүүлсэн шинэ цол олгодог журамтай болсон байна.

Наадамд нэг түрүүлбэл улсын Мэргэн, хоёр түрүүлбэл Даян мэргэн, гурав түрүүлбэл Даяар дуурсах мэргэн, дөрөв түрүүлбэл Дархан мэргэн цол олгодог. Улсын наадамд 2 дугаар байр эзэлсэн харваач Гарамгай харваач цол, 3 дугаар байр эзэлсэн харваач Гоц харваач цол авдаг.

Шагай харваа

Шагай харваж наадах дэг горим нь нэг баг 7-9 эрчүүдээс бүрдэх ба тоглож буй хоёр баг 30 хасаа өрж 9 тохой зайнаас нийллэг, шувтарга, гоц мэргэ гэсэн үеүүдэд баг тус бүрээс 2 харваач сууж тус бүр 4 сум тавьж 3 өрөг харваж нэг нь нөгөөгөөсөө таван хасаа татаж чадсан тохиолдолд хожил тооцдог журамтай. Ингэж тоглох явцдаа тухайн 2 баг дундын сайхан уухайгаар хүндэтгэл илэрхийлж бас урам хайрлан оноо цэц мэргийг нь улам ангиулдаг юм. Шагайн уухай нь бүс нутгийн түмэн олны зан үйл, соёл, хэв маягаас үүдэлтэй дөрвөн чиглэлд хуваагддаг.

- Төв халхын угалз уухай
- Боржигон уухай
- Зуутын идэрийн уухай
- Баруун монгол буюу Дархад уухай гэж төрөлжүүлэн ардын язгуур урлагийн төрөлд багтаан үндэсний соёлын үнэт өв хэмээн үздэг байжээ

Наадмыг 2015 онд ЮНЕСКО «Хүн төрөлхтний соёлын биет бүс өвийн жагсаалт»-д бүртгэн авчээ.

Эх сурвалж: wikipedia.org

НИЙГМИЙН ДААТГАЛЫН САЙН ДУРЫН

ХУУЛИЙН МЭДЛЭГТ

ДААТГАЛЫН ТУХАЙ



Нийгмийн даатгалын сайн дурын даатгалд ямар иргэд хамрагдах вэ?

Ажил олгогчтой хөдөлмөрийн гэрээ, ажил гүйцэтгэх гэрээ болон хөлсөөр ажиллах гэрээ байгуулан ажиллаж байгаагаас бусад иргэн нийгмийн даатгалын сайн дурын хэлбэрт хамрагдаж болно. Тухайлбал:

- Хувиараа хөдөлмөр эрхлэгч
- Малчин
- Газар тариалан эрхлэгч
- Бичил уурхай эрхлэгч
- Чөлөөт уран бүтээлч
- Тодорхой хөдөлмөр эрхлээгүй иргэн
- Гадаад улсад ажиллаж, амьдарч буй иргэн
- Оюутан суралцагч
- Бусад иргэн

Нийгмийн даатгалд сайн дураар даатгуулахад ямар төрлийн даатгалд даатгуулж болох вэ?

Сайн дурын даатгуулагч нийгмийн даатгалын байгууллага (байцаагч)-тай байгуулсан гэрээгээр тохирсон хугацаанд өөрийн мэдүүлсэн хөдөлмөрийн хөлс, орлогоосоо дараах хувь, хэмжээгээр тооцон шимтгэлээ төлнө. Жишээ нь: (хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ 2020 онд 420 000 төгрөг) Даатгуулагчийн сард төлөх шимтгэл $(420\ 000 \cdot 13.5\%) = 56700$ төгрөг байна.

- Тэтгэврийн даатгалд-11,5%
- Тэтгэмжийн даатгалд-1,0%
- Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалд-1,0%

0-3 насны хүүхдээ асрах чөлөөтэй байгаа эхчүүд сайн дурын даатгалын шимтгэлийг эрхэн төлөх вэ?

Албан журмын буюу ажил хөдөлмөр эрхэлж байсан эхийн төлөх шимтгэлийг ажил олгогчоос хариуцан төлнө.

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн дагуу жирэмсний болон амаржсаны тэтгэмж авах эрх нь үүссэн сайн дурын даатгуулагч эх шимтгэлийн 50 хувийг өөрөө төлсөн нөхцөлд 50 хувийг тэтгэмжийн даатгалын сангаас хариуцан төлнө. Жишээ нь: Даатгуулагчийн сард төлөх шимтгэл $(420\ 000 \cdot 12.5\%) - 26250 = 26250$ төгрөг байна.

Бусад буюу жирэмсний болон амаржсаны тэтгэмж тогтоолгоогүй хүүхдээ 3 нас хүртэл асарч байгаа эх сайн дурын даатгалын шимтгэлийн 50 хувийг өөрөө төлсөн нөхцөлд 50 хувийг улсын төсвөөс хариуцан төлнө. Жишээ нь: Даатгуулагчийн сард төлөх шимтгэл $(420\ 000 \cdot 12.5\%) - 26250 = 26250$ төгрөг байна.

- Тэтгэврийн даатгалд-11,5%
- Тэтгэмжийн даатгалд-1,0%

Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс дээш дүнгээр сайн дураар даатгуулах бол тодорхойлсон цалин хөлснөөс 13,5 хувиар тооцож төлөх шимтгэлээс 26250 төгрөгийг хасч үлдсэн шимтгэлийг даатгуулагч төлнө. Жишээ нь: Даатгуулагчийн сард төлөх шимтгэл $(800\ 000 \cdot 13,5\%) - 26250 = 81750$ төгрөг байна.

- Тэтгэврийн даатгалд-11,5%
- Тэтгэмжийн даатгалд-1,0%

Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалд-1,0%

Шимтгэлийг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс тооцон төлөх ба хуулийн үйлчлэлд хүүхэд нь 3 нас хүрээгүй нийт эхчүүд хамаарна.

Иргэд нийгмийн даатгалд сайн дураар даатгуулахдаа шимтгэл төлөх сарын орлогоо ямар журмаар тодорхойлох вэ?

Нийгмийн даатгалд сайн дураар даатгуулах иргэд эрүүл мэнд, нийгмийн даатгалын байгууллагатай тохиролцон хоёр талын гэрээ байгуулах бөгөөд гэрээнд шимтгэл тооцох сарын орлого, шимтгэл төлөх хугацаагаа тодорхой тусгаж өгнө.

Шимтгэл тооцох сарын орлогын доод хэмжээ нь Засгийн газрын баталсан тухайн үед мөрдөж байгаа хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс багагүй байна.

Шимтгэл тооцох сарын орлогын дээд хэмжээ тухайн үед мөрдөж байгаа хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 10 дахин нэмэгдүүлснээс ихгүй байна.

Сайн дураар даатгуулагч нийгмийн даатгалын шимтгэлээ нөхөн төлж болох уу?

Болохгүй. Зөвхөн нийгмийн даатгалын байгууллагатай гэрээ байгуулсан сараас эхлэн гэрээгээр тохиролцсон хугацаанд шимтгэлээ төлнө.

Сайн дураар даатгуулагч шимтгэлийн тооцоог ямар журмаар хийх вэ?

Сайн дураар даатгуулагч нь нийгмийн даатгалын байгууллагатай байгуулсан гэрээнд заасан хугацаанд төлбөл зохих шимтгэлээ банкны тооцооны салбарт орлогын мэдүүлгээр нийгмийн даатгалын сангийн харилцах дансанд тушаана. Уг орлогын мэдүүлгийг үндэслэн

сайн дураар даатгуулагчийн шимтгэлийн тооцоог нийгмийн даатгалын байцаагч хийж, түүний төлсөн шимтгэлийг нийгмийн даатгалын дэвтэрт нь тухай бүр бичиж баталгаажуулж байна.

Сайн дураар даатгуулагч ямар тохиолдолд нийгмийн даатгалын байгууллагатай байгуулсан гэрээгээ цуцлах вэ?

Дараах тохиолдолд нийгмийн даатгалын байгууллагатай байгуулсан гэрээгээ цуцална

- Аж ахуйн нэгж, байгууллагад ажилд орох
- Тэтгэвэр тогтоолгох
- Хүүхэд нь 3 нас хүрсэн эхчүүд

• Нас барах зэрэг тохиолдолд шимтгэлийн тооцоог дуусгаж, аймаг, сум, дүүргийн эрүүл мэнд, нийгмийн даатгалын хэлтэс /ажилтан/ сайн дураар даатгуулагчийн гэрээг цуцалсан шалтгааныг түүний нийгмийн даатгалын дэвтэрт бичиж баталгаажуулж өгнө

Сайн дураар даатгуулагч ямар төрлийн тэтгэвэр, тэтгэмж, төлбөр авах эрхтэй вэ?

Сайн дураар даатгуулагч хуульд заасан болзол, нөхцөлийг хангасан тохиолдолд дараах тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийг авах эрхтэй.

- Тэтгэврийн даатгалын сангаас
 - o Өндөр насны тэтгэвэр
 - o Тахир дутуугийн тэтгэвэр
 - o Тэжээгчээ алдсаны тэтгэвэр
- Тэтгэмжийн даатгалын сангаас
 - o Хөдөлмөрийн чадвар тур алдсаны тэтгэмж
 - o Жирэмсний болон амаржсаны тэтгэмж
 - o Оршуулгын тэтгэмж
- Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас
 - o Тахир дутуугийн тэтгэвэр
 - o Тэжээгчээ алдсаны тэтгэвэр
 - o Хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэмж
 - o Хөдөлмөрийн чадварыг нөхөн сэргээхтэй холбогдсон төлбөр
 - o Тэтгэврийн даатгалын шимтгэл
 - o Рашаан болон мэргэжлээс шалтгаалсан өвчтөний сувилалд ирэх, очих унааны зардал
 - o Мэргэжлээс шалтгаалсан өвчтөний сувиллын тусламж, үйлчилгээний зардал

Сайн дураар даатгуулагч нь шимтгэл төлөх талаар ямар үүрэг хүлээх вэ?

Сайн дураар даатгуулагч нь нийгмийн даатгалын шимтгэл төлөх талаар дараах үүргийг хүлээнэ.

• Хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилгах орлогод ногдох нийгмийн даатгалын шимтгэлийг үнэн зөв тооцон гэрээнд заасан хугацаанд оршин суугаа аймаг, сум, дүүргийн эрүүл мэнд, нийгмийн даатгалын хэлтсийн нийгмийн даатгалын сангийн дансанд төлөх

• Шимтгэл төлсөн тухай орлогын мэдүүлэг /баримт /-ийг хариуцсан нийгмийн даатгалын байцаагчид ирүүлж, төлсөн шимтгэлээ нийгмийн даатгалын дэвтэрт бичүүлж, баталгаажуулж авах

• Өөр аймаг, нийслэл, сум дүүрэгт шилжин суурьших тохиолдолд төлсөн шимтгэлийн тооцоог нийгмийн даатгалын байцаагчтай хийж дуусган, гэрээг цуцлуулж, энэ тухай нийгмийн даатгалын дэвтэрт бичилт хийлгэн баталгаажуулсан байх

Сайн дураар даатгуулагчид ямар тохиолдолд хариуцлага хүлээлгэх вэ?

Сайн дураар даатгуулагч нь сард төлбөл зохих шимтгэлээ эрүүл мэнд, нийгмийн даатгалын байгууллагатай байгуулсан гэрээнд заасан хугацаанд төлөөгүй тохиолдолд дутуу төлөгдсөн буюу хугацаандаа төлөгдөөгүй шимтгэлийн дүнгээс хугацаа хэтрүүлсэн хоног тутамд 0.3 хувиар тооцож алданги төлнө. Энэхүү алдангийн хэмжээ нь төлбөл зохих шимтгэлийн 50 хувиас хэтрэхгүй байна.

Нийгмийн даатгалд сайн дураар даатгуулах асуудлыг ямар байгууллагад тавьж шийдвэрлүүлэх вэ?

Нийгмийн даатгалд сайн дураар даатгуулах иргэд оршин суугаа аймаг, сум, дүүргийнхээ эрүүл мэнд, нийгмийн даатгалын байгууллага /байцаагч/-тай гэрээ байгуулна.

Энэхүү гэрээг 2 хувь үйлдэж 1 хувийг даатгуулагч /иргэн/, нөгөө хувийг нийгмийн даатгалын хэлтэс / байцаагч / -т хадгална.

Сайн дураар даатгуулагч тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн данс нээлгэж болох уу?

Болно. 1960 оны 1 дүгээр сарын 1-ний өдөр ба түүнээс хойш төрсөн сайн дураар даатгуулагчийн хувьд тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансыг даатгуулсан өдрөөс нээнэ.

1995 оноос өмнө ажилласан хугацааг нэрийн дансны орлогод оруулан тооцох уу?

Тооцно. Та 1995 оноос өмнө ажилласан хугацаагаа тооцуулахын тулд хөдөлмөрийн дэвтэр, хөдөлмөрийн дэвтэргүй бол цэргийн батлах, архивын лавлагаа, ажилд орсон, гарсан тушаалын хуулбар зэргийг бүрдүүлж, оршин суугаа газрынхаа аймаг, дүүргийн нийгмийн даатгалын байгууллагын нийгмийн даатгалын байцаагчаар 1995 оноос өмнө ажилласан хугацаагаа тооцуулах хэрэгтэй

Сайн дураар даатгуулахад ямар баримт бүрдүүлэх вэ?

- Иргэний үнэмлэх
- 3x4 хэмжээний зураг - 2 ш
- 1995 оноос өмнө ажиллаж байсан бол хөдөлмөрийн дэвтэр

Сайн дураар даатгуулагч нь үйлдвэрлэлийн осолд орсон тохиолдолд ослын актыг ямар байгууллагад хандаж тогтоолгох вэ?

Сайн дураар даатгуулагч нь осолд өртсөн тухайгаа оршин суугаа аймаг, сум, дүүргийнхээ эрүүл мэнд, нийгмийн даатгалын хэлтэс /ажилтан /-т мэдэгдэнэ.

Ослын актыг аймаг сум, дүүргийн Засаг даргын томилсон байнгын комисс судлан тогтооно.

ХУУЛИЙН МЭДЛЭГТ

ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЦАХИМ /ТУЦ/ МАШИН

ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЦАХИМ МАШИН /ТУЦ/-ААС ЮУ АВЧ БОЛОХ ВЭ?


Энгийн цаасан дээр хэвлэгдэн гарах дараах 28 төрлийн лавлагаа, тодорхойлолтыг авна. Үүнд:



1. Төрсний бүртгэлийн лавлагаа
2. Иргэний үнэмлэхийн лавлагаа
3. Оршин суугаа хаягийн лавлагаа
4. Гэрлэлтийн бүртгэлгүй эсэх лавлагаа
5. Гэрлэлтийн бүртгэлтэй тухай лавлагаа
6. Гэрлэлт цуцалтын тухай лавлагаа
7. Эд хөрөнгөтэй эсэх лавлагаа
8. Үл хөдлөх хөрөнгийн бүртгэлийн лавлагаа
9. Хуулийн этгээдийн бүртгэлийн лавлагаа
10. Хуулийн этгээдгүй тухай лавлагаа
11. Татварын лавлагаа
12. Гаалийн байгууллагад өртэй эсэх тухай лавлагаа
13. Валютын ханшийн лавлагаа
14. Тээврийн хэрэгслийн жолоодох эрх сэргээх үйлчилгээ
15. Тээврийн хэрэгслийн жолоодох эрхийн үнэмлэхийн лавлагааны үйлчилгээ
16. Жолоодох эрхийн лавлагаа
17. Мэргэшсэн жолоочийн лавлагаа
18. Тээврийн хэрэгслийн лавлагаа /өмнө нь өмчилж байсан эсэх/
19. Ачааны автомашинд "ЕС" зөвшөөрөл олгох үйлчилгээ
20. Ачааны машины зөвшөөрлийн баримт авах
21. Нийгмийн даатгалын шимтгэл төлөлт
22. Нийгмийн даатгалын тэтгэврийн эрх
23. Нийгмийн даатгалын ажил олгогч
24. нийгмийн даатгалын нэрийн данс
25. Төрийн үйлчилгээний цахим системд нэвтрэх эрх
26. Цахилгааны төлбөр төлөх
27. Шүүхийн шийдвэрээр төлбөргүй эсэх лавлагаа
28. Боловсролын бичиг баримтын лавлагаа

Монгол Улсын Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөр, "Цахим засаг" үндэсний хөтөлбөрийн хүрээнд "Иргэдийн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийг хянах мэдээллийн систем бий болгох," "Иргэдийн өргөдөл, гомдлын мэдээллийн ухаалаг тайлангийн систем" төслүүдийг хэрэгжүүлж төрийн үйлчилгээг орон даяар жигд хүртээмжтэй, түргэн шуурхай хүргэх зорилгоор 2013 оноос эхлэн Төрийн үйлчилгээний цахим машин буюу ТУЦ машиныг үйлчилгээнд нэвтрүүлж эхэлсэн.

Хэрэглээ маш энгийн. Иргэн та иргэний цахим үнэмлэхээ зааврын дагуу машинд хийхэд дэлгэц дээр хүссэн мэдээлэл, лавлагааг авах цэс нээгдэнэ. Цэсийг дарснаар дэлгэцэн дээр таны хүссэн лавлагаа мэдээлэл гарч ирнэ. Тэр үед лавлагаа, мэдээллийн хураамж болох 500-1000 төгрөгийг машинд хийнэ. Машины доод хэсгээс гарч ирэх тасалбарыг аваад хадгалах шаардлагатай. Учир нь уг тасалбар таны мэдээллийг явзвэлсэн үнэт цаасны хамт байснаар албан ёсны баримт болох ажээ. Мөн бэлэн мөнгөгүй яваа бол банкны цахим картаа ашиглан төлбөр тооцоо хийх боломжтой.



УРАНЗОХИОЛ

Хэрээний нулимс



Төрийн соёрхолт, зохиолч, сэтгүүлч Д.Норов

Хөөө та минь ээ, доройтсон нүдэнд юу сайныг та нар дуулсан уу? гэж яншаа ёнгинуур дуугаар орилсоор Баярт гуай ирж явна. Халуун зун үстэй дотортой зузаан ултай гутал, хөвөнтэй торгон өмд цамц өмсөөд, нэг гартаа зөөлөвтэй сандлаа барин нөгөө гараар таягаа тулсан, тас хар шил зүүсэн майцгар өвгөн тийн дуугарсаар ойртон ирэхэд сэхээвчинд суугаа хөгшчүүд тоглоомдоо улайраад хариу дуугарсангүй, шуугилдана. Хэзээ хойно, Тэгвэл наад хоёр улчнаа эмчлээч гэх тохуутай дуун гарав. Тэгтэл тэр дуугарагчтай өрсөлдөх мэт Хүүе, Баярт гуай, Баярт аа, нааш ир, энд суугаад сайхан ярь гэж тоглоомын талбайн нөгөө захасаа хоёр эмгэн зэрэг зэрэг дуудахад өвгөн тэдэн рүү хаазганасхийн зүглэв. Энэ бол манай хорооллын "орилоо шар" өвгөдтэй нийлж даалуудаж хөзөрдөхгүй атлаа өдөржин энэ талбайгаар сандлаа чирэн холхиж, хөгшин залуу, таних танихгүй хэнийг ч болов "хөөө хө, сайн уу. Чи дуулсан уу" хэмээн тэртээ ходоос дуудан ямар нэг сонин содон юм хэлнэ. Улс төр, хүүхдийн сахилга, тамхины хор, телевизийн шинэ мэдээ, ер ярихгүй сэдэв байхгүй. Харин эндхийнхэн бүгд түүнээс дайжин холдоно. Тэгвэл өвгөн гомдоно гэж үгүй. Заримын нь хойноос даган гэлдэрч, мөнөөхөө ярин залхаана. Түүний жонгиносон шингэн дуу талбайн хаана ч тод сонсогдоно. "орилоо шар" гэх хогийн ерийн нэршилээс илүү нэг л зэвүүн хүйтэн өнгө сонсогдоно. Учир нь "энэ орилоо шар чинь насаараа эмнэлгийн хүүр задалдаг ажил хийсэн юм гэнэ лээ" гэсэн яриа тархаснаас хойш хүмүүс түүнээс дайжих болсон юм. Өвгөн ч үүнийг нь анзаардаг бололтой, цэцэрлэгт талбайн сандлуудад налайж суугаа хүмүүстэй суудал булаалдахгүй, өөрийн сандлаа чирч ирээд ойролцоохон суугаад жонгиносон ярьж гарах. Бүсгүйчүүд хүүхэддээ /энэ өвгөнд битгий ойрт. Чихэр өгвөл сэмхэн хаячихаж бай. Идэж болохгүй

шүү. Муухай хүн байгаа юм/ гэхчилэн захиж, өөрсдөө холуур дөлж явна. Тэгсэн атлаа чихэр өгөхөд нь авахгүй байж чадахгүй. Ярвайсхийн авч баярлаж гялайснаа хэлэх мөртлөө холдмогц хогийн сав руу чихрийг нь хаяад гараа арчин "тфү тфү, муу юм цаагуур" гэх. Авахгүй байхаас айна. Авсан хойно айна. Чихрээс айж байгаа нь тэр.

Би өвдсөн нүдэнд юу сайныг сонсох санаатай тэрүүхэнд саатан суутал өндөр туранхай өвгөн бас ирж зэрэгцэн суух зуур,

-За манай хөгшин хэрээ өнөөдөр юу гэж гуаглаж байна гэв?
Энэ бол бас манай хорооллын "зангиа". Өдөр шөнө, өвөл зунгүй зангианаас салдаггүй хүн. Тиймээс эндхийн авгай нар түүнийг зангиатайгаа унтдаг гэж баталцгаадаг юм.

-Одоо л сонсоё гэж би товч хариулав
-Энэ хэрээ мөд үхэхгүй, олон жил гуаглах байх шүү гээд "зангиа" шүлсээ гэдхийлгэн хаяв.

Энэ өвгөн олон үггүй юм шиг атлаа дандаа тэр энэ хүн болон үйл хэргийн сүүдрийг гоочилсон зэвүүн үг хэлдэг болохоор нь эндхийнхэн бас түүнд дургүй. Гэвч нэг их айж дайжаад байдаггүй юм. Харин "зангиа"-т нь "орилоо шар"-ыгаа бол дандаа үзэн ядсан нэг юм хэлж явдаг ажээ.

За тэгээд юу сайн гэнэ. Хаанаас мэдэв хэмээн хоёр эмгэн зэрэг зэрэг асуун дэргэдээ суудал зайчлан саймшрах нь энэ удаад өвгөнөөс зэнзийлэх цээрийг нь сонсох хүсэл нь дийлэв бололтой. Гэвч Баярт гуай өмнөхөн нь сандлаа тавин сууж тухлаад хэлж байна.

-Хэрээний нулимс... Хэрээний нулимс нүдний ямар ч өвчнийг хойш урагшгүй нам болгодог гэнэ шүү хө. Хэрээ нөгөө дандаа нүд иддэг амьтан болхоор тэр гэнэ ээ.

-Тэр олон нүднээс чинь аль хэрэгтэйг нь сороод залгичихдаг болохоор нулимс нь тунгаасан эм бололгүй яахав.
-Хүүе ер, нээрэн тийм ш дээ. Үгүй тэгээд тэр хэрээний чинь нулимсыг яаж олдог байна.

-Амархан гэнэ ээ. Согтоож байгаад авчихдаг юм гэнэ. Согтоож ий. Нүгэл байгаа даа, тэгээд хар хэрээтэй архи уух хэрэг үү?

-Уусан ч яадаг юм. Зах дээрээс хонины толгой худалдаж аваад хоёр нүдэнд нь шпирецээр архи шахаад гадаа хаячихгүй юу даа.
-Өө хөөрхий тэгээд тэрийг нь тоншоод нөгөөх нь согтчихдог байх нь.

-Тэгэлгүй дээ. Тэгээд нисч чадахаа байчихаад, хэдэн зуун жил улай зовлон үзсэн амьтан болохоороо тэрийгээ санадаг биз. Уйлаад бөмбөрөөд байдаг юм байх аа.

-Ээ чааваас гэж. Үгүй тэгээд үнэн л байдаг байгаа даа, айн. Тэгж үзсэн хүн байна гэнэ үү? Байна аа байна. Хаа сайгүй л.

-Ишш Баярт минь. Чи эрх биш эр юм байна даа, нэг арга бодооч. Хоёулаа дуран шиг нүдтэй болчихъё л доо гэгцгээж биесээ нудралцан инээлдэв.

Энэ өдрөөс хойш хэдхэн хоногийн дараа "хэнгэрэг хагарна" гэгч болов. Орой ажил тараад иртэл манай байрны өмнөх ганц аварга том улиасны орчимд эхнэр хүүхэн голцуу хоёр гурваараа зогсоод шивэр авир гэлцэж мод өөд заацгааж, хар хэрээд бархиралдан, мод тойрон нисэж заримдаа газар шүргэн алдан доош шунган дайрч, хүүхдүүд тэдэн рүү чулуу шидлэн "яваач, зайлаач" гэж хашгиралдан байв.

Есөн давхар байшинтай жацуу энэ аварга улиас бол манайхны ганц бахархал юм. Навчис дундаа сувууны нэг лут сайхан үүртэй юм. Би юу болсоныг сонсууцарх мөнөөх гөргөр "зангиат"-д ойртон очвол тэр толгой дохин мэндлээд

-Одоо нөгөө хөгшин "хэрээ" хэрэгтэй байна санж гэж дуугарав.

Би гайхасхийн асууж харвал

-Энэ хавьд явдаг нэг муу шар муур дээш авирч очоод үүрэнд байсан хэдэн ангаахайг нь бариад ирчихсэн л дээ. Тэгээд л энэ хоёр хэрээ галзуурч өдөржин бархирч модонд ойртсон бүхэн рүү дайрч байгаа юм гэв.

-Хөөрхийс үрт амьтан гэгч. Энэ хоёр эцэг эх нь байхдаа гэвэл өндөр өвгөн ийш тийш өлөдзөн

-Нөгөө "орилоо шар" хайчив аа. Хэрээний нулимсанд дуртай юмсан. Энэ хоёрыг барьж авбал одоо ч нэг асгаруулж өгнө дөө. Яг хэрэгтэй үед нь алга болчих юм. Бас тэр шар муурыг олж орилоогоор төхөөрүүлээр байна. Тэрэнд айдас хүйдэс, эрээ цээр гэж байх биш гээд хямсайн инэмхийлэв. Тэгтэл ард зогсож байсан нэг охин "Орилоо өвөө" нулимсаа арчаад зогсож байсан. Харьсан байх аа гэж "зангиат"-руу зэвүүцэнгүй хялбалзан хэлээд эргэн одов. Миний сэтгэл зэхийрч, дотор хүйт оргиход би гэртээ оров. Гэвч тохитой сууж чадсангүй. Гадаа хэрээ зогсоо чөлөөгүй бархирах, эх хүүхдээ дуудан зандрах, зайлаач яваач гэж багачууд хашгиралдах дуулдсаар бүтэн оройг түгшүүрээр дүүргэж орхив.

Золоор маргааш нь амралтын өдөр тул аажуу босож гадагш гарвал өчигдрийн түгшүүр нилээд намжсан бололтой. Мөнөөх хоёр хэрээ тамираа барсан, цөхөрсөн ч юм уу, шонгийн модны оройд сууж хааяа «гон гон» хийн гоншигнож байв.

Харин хүүхдээ салхилуулсан, нарласан эхнэр хүүхнүүд бөөгнөрөн нэгэн зүйлийг шогшрон хүүрнэлдэхийг сонсвол "орилоо шар" гуай елөөө хугалж, хавиргаа гэмтээсэн, эмнэлэгт хүндхэн байгаа гэлцэнэ. Учрыг асуувал ангаахай идсэн муурыг "зангиат" гуай шийтгэхээр шийдэж, хүүхдүүдээр бариулаад ойролцоох траншиний худагт хийгээд тагличихсан юмсанж. Мөнөөх жаалуудаас үүнийг сонссон "орилоо шар" амьтан тамлав гэж ихэд уурсан мөнөөх худгаас муурыг гаргах гэж байгаад дотогшоо унаж тийн хэмхэрсэн ажээ.

Худагт орж муурыг гаргах зоригтой жаалууд олон байсан боловч өвгөн тэднийг хавьтуулаагүй гэнэ. Нөгөө хэрээний нулимс авах ч хаа байхав. Хэн нь хэрээ, хэн нь муур юм бэ дээ гэмээр юм болоод дотор зэгийлгэсээр өнгөрөв. Бид ч мартагнав. Гэтэл сар гаруйн дараа эхэн намрын нэгэн налгар сайхан өдөр хүүхдийн талбай дунд тэргэнцэрт суусан «орилоо шар» гэх Баярт гуайтай тааралдав. Хөл муут хүний тэргэнцэр дээр суугаад дугуйг гараар өнхрүүлэн

"Хөөө сайн уу хө, өнөөдөр чинь ялалтын өдөр, баярын мэнд хүргэе" гээд улам цээл болсон жонгиноор дуугаар холоос мэндлэв. Ойртон очвол давхар эмжээртэй морин хүрэмнийхээ энгэрт "Халхин гол 1939" гэж латинаар бичсэн "дайн оролцсон ахмад дайчин" гэсэн хоёр тэмдэг зүүжээ. Би өвгөнтэй мэндлээд тэслгүй мөнөөх хэрээний нулимсыг асууж орхив. Өвгөн инээж, Надад хэрэггүй ээ хө. Тэр авгайчуулын нүдэнд л гээд хар шилээ авбал ухархайдаа цийгээд цайчихсан хоёр нүд хөдөлгөөнгүй бүлтийж харагдав. Харин чихийн нүхнээс сонголын жижиг хэрэгсэл хар нүд мэт бултайж байлаа. Өвгөн

«Хөөө та минь ээ. Өнөөдөр чинь Халхын голын ялалтын өдөр. Та нар мартаагүй биздээ» гэж жонгиносон орилсоор сэхээвчинд суугаад даалууны гуншин уянгалуулж байгаа хөгшдийн зүг дугуйгаа өнхрүүлсээр одов.

Харин мөнөөх аварга улиасны мөчир дээр нулимсаа ширгээсэн хоёр хэрээ таг дуугүй нэвсийн суугаад доор нь нүүр буруулан зогсоод талхны булан дээр архи цутган, хүн харчих вий хэмээн ийш тийш хялалзан, тэднээс нулимс авах аргаа хийж байгаа "зангиат" өвгөнийг уйтгартайяа ширтэн байлаа.


"Утгын чимэг-2019" богино өгүүллийн наадмын тэргүүн байрт шалгарсан өгүүллэг

БҮТЭЭН БАЙГЦУЛАЛТ

4 29 дүгээр хаалттай хорих анги-Төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг нь хоригдлын сургалтын танхим, зан үйлийн өрөө, цахим уулзалтын өрөөг засварлан хоригдлын суралцах орчин нөхцлийг сайжруулан ажиллаж байна.



Завхан аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар нь хоригдлыг нийгэмшүүлэх ажлын үр нөлөөг дээшлүүлэх хүрээнд тэдний бие даан сурч боловсрох, өөрийгөө хөгжүүлэх, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, шашны зан үйл үйлдэх нөхцөл боломжоор хангах зорилгоор тус газрын цагдан хорих байранд шаардлагатай ширээ, сандал, дэвтэр, бал, харандаа зэрэг хэрэглэгдэхүүнтэй, Монголын болон гадаадын уран зохиолын ном, сурах бичиг, шүлэг, яруу найраг, боловсрол соёлын, амьдрах ухааны, шашны, эрүүл мэндийн, танин мэдэхүйн зэрэг төрлийн хоригдол, хоригдогч нарын сэтгэл зүйд эерэг нөлөө үзүүлэхүйц 400 гаруй ном /сонин, сэтгүүл/ бүхий "Номын сан, зан үйлийн өрөө"-г шинээр тохижуулж, ашиглалтад орууллаа.



"ӨӨРИЙГӨӨ ХӨГЖҮҮЛЬЕ" АЯНЫ ХҮРЭЭНД

Шинэ коронавирус "COVID-19" өвчнөөс урьдчилан сэргийлж, Улсын онцгой комиссын шийдвэрийн дагуу Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын 2020 оны А/28 дугаар тушаалаар "Өндөржүүлсэн бэлэн байдалд шилжин" ажиллаж байгаатай холбогдуулан хоригдлын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, хувь хүний бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэх, эерэг зан үйлд төлөвшүүлэх, сэтгэл зүйн байдлыг тогтвортой байлгах, тэдний дундаас гарч болзошгүй гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор "Өөрийгөө хөгжүүлэх" 45 хоногийн аяныг 2020 оны 02 дугаар сарын 19-ний өдрөөс хорих анги, байгууллагад зохион байгуулж ажилласан. Аяны хүрээнд 433 дугаар хаалттай хорих ангид ял эдэлж буй Чулуунбаатар овогтой хоригдол Нацагдорж нь 6 жил хорих ял эдлэх хугацаандаа бие даан орос, англи хэл сурсан ба орос хэлнээс орчуулсан /Константин Симонов "Свеча"/ цэрэг дайны сэдэвтэй "Лаа" өгүүллэгийг "Эх орны манаа" сонинд нийтлүүлэхээр материалыг хүргүүлж, тус сонины "Захидал ирлээ" буланд нийтлэгдсэн нь цаашид өөрийгөө хөгжүүлэх урам зоригийг нэмсэн.



4 05 дугаар хаалттай хорих ангийн Тусгай нэгжийн хоригдлуудын дунд "Миний мөрөөдлийн гэр" гар урлалын бүтээл хийх уралдааныг зарлан, "Их хөлгөний уламжлал хадгалах төв" төрийн бус байгууллагын тусламжтайгаар хоригдол тус бүрт 80 ширхэг бичгийн цаас, 30 ширхэг өнгийн цаас, дэвтэр 1 ширхэг, цаасны цавуу зэргийн олгосон байна. Нийт 11 хоригдлын бүтээлийг шалгаруулж, ангийн арга зүйн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн 9 хоригдолд шагналын 7-10 хоногийг олгож, 2 хоригдлыг өргөмжлөл үнэ бүхий зүйлээр шагнаж урамшуулсан байна.

Хэнтий аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар-419 дүгээр нээлттэй хорих ангийн нийгэм сэтгэлзүйн нэгж нь "Монгол бичиг"-н дугуйланд 5 хоригдол, "Илтгэх урлаг"-ын дугуйланд 7 хоригдол, "Ном уншиж, уншсан номын тэмдэглэл хөтлөх" дугуйланд 9 хоригдлыг хамруулж, нийт хоригдлуудад илтгэх урлаг болон өөрийгөө бусдад хэрхэн зөв таниулах талаарх сургалтыг зохион байгуулсан.



ҮЙЛ ЯВДЛЫН МӨРӨӨР

423 дугаар нээлттэй, хаалттай хорих анги нь 2019 оны 05 дугаар сараас эхлэн Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулдаг “Ноосон урлалын хоршоо”-той, хамтран ял эдэлж байгаа 230 хоригдлыг мэргэжлийн чиг баримжаа, хөдөлмөрийн дадлага олгох сургалтанд хамруулан ажлын байраар хангаж, ноос самнах, эсгий хийх, гар оёдол, хэвлүүрийн шаахай, эсгүүрийн шаахай, эсгий бойтог, арьсан гутал, ширмэл ширдэг ширэх, зүү ороосон арьсан бүс, зүү ороосон бурхан бүтээх, бэлэг дурсгалын зүйлс хийх, эсгий зураг зэрэг брэнд бүтээгдэхүүнийг үйлдвэрлэж байна.



Архангай аймаг дахь ШШГГ-ын ЦХБ-ны аж ахуйн үйлчилгээнд ял эдэлж байгаа хоригдлуудын дунд цаг үеийн халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх нөхцөл байдалд тохируулж, 2019 онд “Цаасан урлал”-ын дугуйланд суралцаж чадамжийн гэрчилгээ авсан нэр бүхий 1 хоригдлоор бусад хоригдлуудад цаасаар урлал хийх сургалтыг зохион явуулж байна.



417 дугаар нээлттэй хорих анги нь гар урлалын сургалт явуулдаг бөгөөд сургалтад хамрагдсан хоригдлуудын хийсэн бүтээлийг танилцуулж байна. Үүнд: Шигтгээн наамал, уран зураг, гипсэн баримал, эсгий урлал.



ОЛОН УЛСЫН ХҮҮХДИЙН ЭРХИЙГ ХАМГААЛАХ ӨДӨР



407 дугаар нээлттэй, хаалттай хорих анги нь “Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдөр”-ийг угтан нярай хүүхэдтэй хоригдлууд болон тэдний хүүхдүүдийн дунд 2020 оны 05 дугаар сарын 22-ны өдөр “Манцуйтай тамирчин” хөгжөөнт тэмцээнийг зохион байгуулж 10 эх, хүүхдийн хамт оролцож хурд хүч, авхаалж самбаагаа сорьж нэгэн өдрийг хөгжилдөн өнгөрөөсөн байна.

Хүүхдүүдийн дунд “Машин болон хөлд оруулагч тэрэгний уралдаан”, “Азын бөмбөлөгтэй бэлэг сугалах”, эхчүүдийн дунд “Хэн сайн мэдэрч зурах вэ?” зэрэг хөгжөөнт тэмцээнийг зохион байгуулсан.

Тэмцээнд оролцсон эх, хүүхэд бүрийг нэмэлт сүү, живх бялуугаар шагнаж урамшуулж, эхчүүдэд талархалын бичиг гардуулсан.



Машин болон хөлд оруулагч тэрэгний уралдааны үеэр

Нярай хүүхэдтэй нийт эхчүүдийн дунд “Хэн сайн мэдэрч зурах вэ?” сэдэвт зургийн уралдааныг зохион байгуулсан.



Уг арга хэмжээнд хоригдол М.Отгончимэг “Миний ээж хөөрхөн” дуу, хоригдол Ч.Баттуул “Боржигоны бор тал” шүлгийг уншиж эх, хүүхдүүдэд баярын мэндчилгээ дэвшүүлсэн.



Мөн уг арга хэмжээний үеэр хоригдлуудын ар гэрээс ирүүлсэн мэндчилгээг цахим хэлбэрээр хүргэсэн байна.

ХҮМҮҮЖИГЧИЙН БУЛАН

*Бурханы өрөнд байлаа ээждээ өрлөх
сэтгэлийн минь заххидай*

Алтан нарны элч шиг элгэн халуун хайраар анхилуун цэцгийн дэлбээ шиг эхийн нандин сэтгэлээр алдах, онохыг хослуулсан хүний хувь зохиолоор алдар багатай явсан жирийн хүний амьдралаар самган буурал ээж минь намайг төрүүлж, өсгөсөн билээ.

Нартад төрүүлсэн эх үрийн жаргал эгэл хүн ээж таныгаа мөнхийн юм шиг санаж явжээ, ээжээ. Аргал, усанд явахад нь дээлийн захыг нь үнэрлэж, алсын барааг хааяа сэм сэм харуулдаж, айлын хүүхдүүдэд хааяа шоглуулахдаа ээждээ чамайг хэлнэ дээ гэж ам бардам айлгаж, дэрвэж явсан балчир бага үе минь санагалзан бодоод байхад саяхан юм шиг байвч санаандгүй урсах он жилүүдийн дөч дэх нүүрийг үзэж саад бэрхийн өмнө толгой бөхийлгөж үзээгүй хүү нь сайхан сэтгэлт ээждээ сайн хүү нь байж чадсангүй ээ, уучлаарай. Уг нь та намайг сарьдаг өндөр уулс дунд тэнгэр бурхантай ойрхон төрүүлсэн юмсан. Даан ч дээ хүү нь итгэл, сэтгэлийг тань даасангүй дээ, ээжээ. Хан тэнгэрийг баганадсан сүрлэг уулсын бэлд төрсөн би хараа сунган цэлийсэн халхын тал нутагт өсч, хатирт морины жолоог сүргийн зүг эргүүлж, нутаг усандаа алдартай, галтай залуусын нэг болж өслөө. Дэндүү их хайр халамжинд явахдаа ээжийг хайрлаж, энэрч чадаагүй хайхрамжгүй өнгөрөөждээ. Эрин цагийн эрхээр өнчин зүрх нь шархалж, эрэн алаг амьдралын жамыг дагасан юм. Хот аймаг алгасаж, хувь заяагүй амьдралын хуурамч бүхнийг амсч, таньж мэдэхгүй хүмүүсийн дунд өвдөг сөгдөн мөргөсөнгүй. Тарчиг хатуу амьдралын зовлон үзсэн ч гуныж гутарсангүй. Найз, нөхөд, бөө, лам гэх мэт олон хуурамч хүмүүсийг таньж мэдлээ. Бусдад буян түгээж, ач тус хуртэн гэдэг боловч ашиг сонирхолын үүднээс өргөл барьц нэхдэг ийм харгис хатуу хүмүүний амьдрал туулж явна даа. Ээжийн минь амьд сэрүүндээ үйлдсэн буян тань буцаад надад ганц охин болж ирсэн шүү. Тийм болохоор хүү нь ахиж алдах эрхгүй, амьдралын төлөө зүтгэх эрмэлзлэлтэй болсон. Хийсэн хэрэг маань архины халуунд шүү ээжээ. Харин хүнийг хайрлах энэрэх сэтгэл минь хэзээ ч хувирахгүй ээ ээжээ. Горхины тунгалаг урсгал шиг сэтгэл дээр минь бодлын цолмон өглөө бүхэн гийж байг. Таныгаа нутаглуулсан цэцэгт талдаа хүү нь тэргүүндээ буурал суухаас өмнө эрх чөлөөтэйгөө цуг эргэж очно оо.

Ээжээ буянт буурал цогцос тань газар шороондоо шингэсэн ч ариун дагшин сүнс тань бурханы орноос намайг харж байгаа гэдэгт итгэж байгаа шүү ээжээ. Хүү нь гал шиг дүрэлзэж чадахгүй ч, цог шиг улалзаж амьдрах болно оо. Амлаж байна ээжээ. Хүүдээ этгээд мөнх тайван нойрсдоо, ээжээ. Ээжээ таны хэлдэг үгийг одоо ч би хэлэх дуртай. Хүний итгэлийг дааж чадахгүй хүний сэтгэл хүйтэн байдаг гэдэг дээ.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын хамт олон, харьяа байгууллагын хамт олонд нийт хоригдлуудын өмнөөс баярласан сэтгэлээ илэрхийлье.

Энэхүү “Өчил” сонинг гаргаснаар танин мэдэхүй, ухаарал, амьдрах урам зориг хайрласан олон арга хэмжээ давхар явдагт сэтгэл хангалуун байна. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа бүх алба хаагч болон тэдний гэр бүлд аз жаргал, эрүүл энхийг хүсье.

Энэхүү захиаг хожимдсон ч гэсэн бурхан болсон ээждээ бичих боломж олгосон “Өчил” сонинд баярлалаа.

439 дүгээр хаалттай хорих ангийн тусгай зэрэглэл
Уртнасан овогтой Хоригдол Амгалан

Ээждээ бичсэн заххидай

Миний ээж Говь-Алтай аймгийн Тамир сумын Тарлан хайрханы өвөрт 1960 онд төрсөн Намжилын Наранцэцэг гэдэг хүн бий. Ээж маань гурван хүү, гурван охин төрүүлсэн ачтан. Үр бид нь муу ээжийгээ уйлуулж, дуулуулж л хүн болцгоосон. Ээжийн маань өвөө нутаг усандаа алдартай мундаг номтой лам хүн байсан болохоор буян заяа нь үр ачдаа нарны цацраг мэт ивээл болж ирсэн буй за. Номын ид шидтэй ачтаны буян ижийд минь ирж сайхан хань, үр хүүхэд заяажээ. Тиймдээ ч энэ хорвоод ханилсан хань, заяасан үрстэйгээ эрүүл саруул, элэг бүтэн амьдрахаас илүү жаргал бий гэж үү хэмээн ижий минь залбирдаг юм. Арван цагаан буяны эхлэл ижийгээ бурханы дээд хишиг хэмээн хайрланам. Эгэл жирийн хэрнээ аугаа их увидас нуугдсан миний ээж өөрийн хүний гэж ялгалгүй санаа зовж ерөөл өргөж явдаг хүн. Хүний хайлан гэж миний л ижийг хэлнэм. Үр хүүхэд биднийгээ амьдралын далайд хөл алдан живэхгүй, зомгол мэт хөвөхгүй, хүн шиг хүн болгож хүмүүжүүлэхийн төлөө бүхнээ зориулжээ. Арван сар хэвлийдээ тээж ангир шар уургаа шимүүлэн өсгөсөн таныгаа үрийнхээ төлөө үргэлжид зовиносон сэтгэлийн тань гэрэлд сөгдөн мөргөө. Алдааг минь цагаан сүүгээрээ аргадаж буян далласан ачит ижий таныгаа тэргүүнд тодорсон үрчлээс, санчиганд харвасан мөнгөн сорны тань тоогоор хүлцэл өчье ээж ээ. Энэ хорвоод насаар минь үнэнч үлдэх ганцхан дарь эх миний ижий билээ. Хайрын цагаан гэгээгээр амьдралыг минь сүлж, аз жаргалын амтыг мэдрүүлсэн таньдаа залибарнам. Хорвоод учир холбоогүй юм гэж даанч үгүй мэт, намайг хэрэг хийсэний маргааш надруу залгаад миний хүү зүгээр үү, ээж нь хүүгээ маш муухайгаар зүүдэллээ гэж билээ.

Өнгөтэй өөдтэйг өмсөнө гэж өрөнд унагааж байсанч

Өгч л байхын сэтгэлтэй өглөгч дагина ижий минь.

Энэ шүлгийн мөрүүд миний ижийг хэлж үр нь алдвал өрцөө цөмөртөл мэгшдэг ижийдээ өнө удаан үргэлжид жаргалын илчээ үрсдээ түгээхийн гэгээн ерөөлийг өргөө. Нүнжиг тогтсон сэтгэлийн тэргүүн сэнтийд залрах хувь өндөр ижийн минь жаргалтай инээднээс илүү бэлэг надад үгүй. Таныгаа инээдээр дутааж алдаагаар дарсан тэнэгхэн үрээ өршөөж хайрлаарай, өлмийд тань мөргөө. Өршөөж авраарай ижий минь ээ.

Арван долдугаар жарны шороон гахай жилийн

Өвлийн агаг сарын шинийн арван тавны өдөр бичиглэв.

425 дугаар нээлттэй хорих анги
Мөнхтуул овогтой Хоригдол Намцэрэн

Хөөрхий ижий минь хонин бор нүднээсээ бүлээн нулимс унагаж
Хорвоогийн хатууг гайхан уйлж үлдсэндээ
Хөөрхий ижий минь хэмээх...

*“Эхийн сэтгэл” буюу Үлжийтэйлээ
яруулсан шүлэг*

1-р хэсэг /Эхлэл/

Ухрааж боломгүй өнгөрсөн амьдралаа ухаандаа хүү нь нэхэн дурсахад
Уудам буурал хорвоо ертөнцийн уйтгарт өдрүүд хөврөн өнгөрнө.

Гуниг дагуулж байж хувьсал авч ирсэн, гутрал чирэн байж хувьсал авч ирсэн

Гундуу гандуу тэр нэгэн өдөр хүү нь улсынхаа хуулиас гажин байсан
Уурынхаа мунхагт гашилж байлаа, унаган төрхөө алдаж байсан

Улангассан араатанд хувилж байсан, уйлаад уйлаад ухаарашгүй улаан өдөр

Ухаанд минь уяатай ургашгүй намтарт өдөр

Бүслүүртэй гэрийн дотор бүлээн чулуу өнхрөв

Бүслүүргүй орчлонгийн дотор бүл нэгээр хасагдав

Хэцүүхэн ч гэлээ хуулийн дагуу

Хүйтэн цэвдэг хонгилоор алхаж, хүрэх ёстой газраа хүрвэ

Хүсээгүй ч гэлээ хорвоогийн жамаар хүний олон хүний дунд амьдрах болов

Хар дарсан зүүд шиг тэр өдрүүдэд

Хамаг сэтгэл зүрх минь хоосорч ,хурц зөн билэг минь сохорч

Хайш яаш бодол санаа минь замхрав.

Нэр гэх зүгээр л хэдэн үсэгтэй, нас гэх зүгээр л хэдэн тоотой

Нэг хувь хүн гэх биетэй нийгмийн гадна оршигч

Нийтийн жишгийг гажигч

Амьсгалаа ажиглахаас өөр ажилгүй

Алхаагаа тоолохоос өөр хүсэлгүй

Азаа алдаад эзэд хүрэгч

Арчаагүй нэгэн болон хувирсансан.

Хөөрхий ижий минь л харин

Хонин бор нүднээсээ бүлээн нулимс унагаж

Хорвоогийн хатууг гайхан уйлж үлдсэндээ хөөрхий ижий минь

Бурууг өөрөөсөө хайх нь буянтай хүний зан юм

Бусдыг уучилж хайрлах нь бурхны бүтээлийн жам юм хэмээх

2-р хэсэг /Өрнөл/

Хайран хүү минь хайран хүү минь харж хандах минь яавдаа

Хажир хатуу хорвоод хайрлаж явах минь яавдаа

Хүний дайтай өсгөх гэж хөлсөө дуслуулах минь яав даа

Хүний гарт өгчөөд хөлчүүрхэж явсан минь яана даа

Хорвоод ханиа алдаад ганцаардаж явсныг ч хэлэх үү

Хонгор үрсээ дагуулаад ганьхарч явсныг ч хэлэх үү

Хатуу гэхэд хатуу нь газар дэлхий л байсан

Хажигч уйлан цөхөрч, гашуун дарстай нөхөрлөсөн

Хамгийн хэцүү өдрүүдийг тэгж л хөлчүүрхэж давсан

Хаанаас ч ирээд ойр тэргүүн замыг олоогүй ээ

Авга нагац нартаа алаг үрсээ атгуулчаад

Алтан дэлхийд эжий нь алсын бодолгүй л амьдарч дээ

Авааас тань өөр гарз ахиад ирэхгүй л гэж сэтгэж

Аль эсвэл ахиад алдахаас айсан ч юмуу

Арав хүрэхгүй настай алия хөөрхөн зантай

Хос хосоороо төрүүлсэн холбоо дөрвөн үрээ

Холын хол хот хөдөөд амьдруулсан юмсан

Хожим хойно бага хүүгээ эх нутгийн их айлд

Эргэж буцах нь бэрхтэйгээр амьдарна гэдгийг

Эх нь даанч санасангүй Эвий муу үр минь

Ижийтэйгээ өсөх хувьгүй элдвийн газраар явсаар

Эргээд ижийдээ ирсэн ч ижий муу болохоор

Эргээд буцаад явчихлаа ийм л үйлтэй хүн дээ би

Ижийгээ уучлаарай хүү минь

Хүрэх ёстой оргилдоо та минь хүрсэн ээжээ

Хүүхэд төрүүлж өсгөнө хэмээх нь

Хүмүүний дээд оргил юмаа ээжээ. хэмээх

3-р хэсэг /Төгсгөл/

Үгүй дээ ижий минь ингэж бүү бод

Үүрд та минь үрийнхээ хувьд үндэс язгуур минь хэвээрээ

Уучлалт гуйх хэрэггүй ээ ээжээ,

Уг зүй нь хүү нь танаасаа уучлалт гуйнаа

Ухаант хүмүүн аль алдаж онохыг хэлж барах вэ?

Уулын цэцэгс аль ургаж хагдрахыг тоолж барах вэ?

Урд нэгэн цагт хүү нь тандаа гомдож явсан үе бий

Унаган ачийг тань ухаараад уучлахаас өөр зам үгүй

Талаар нэг сэтгэлээ бэлчээгээд

Тавгүйрхэж гуниад яах вэ ээжээ

Та минь хүүгээ төрүүлсэн тань хамгийн том буян

Таныгаа тарьсан цэцэг болсон үр нь

Таван тивээр алагласан цэцэгс болон дэлгэрдэггүй юмаа гэхэд

Таныгаа сэтгэлд үүрд дэлгэрч буй хэвээрээ үлдэхсэн ээжээ

Хүйгээр холбоотой ижийг минь

Миний хайрт ЭХ “БОЛОРМАА” гэнэ

Хүчил төрөгчөөр холбоотой ижийг минь

Хүндэт ЭХ “МОНГОЛ” гэнэ

Хүний зэрэглээ яваарай гэж бүүвэйн дуугаа зүрхэнд минь шивнэсэн

Хөл алдаж бүдрэх бүрд минь сүлдэт дуугаа сэтгэлд шингээсэн

Хүндэт хоёр ижий минь хүлээж суугаарай

Эхийнхээ хэвлийд хэдэн сар хоригдож миний гэх бие минь бий болсон шиг

Эх орныхоо хэвлийд хэдэн жил хоригдож, миний гэх ухаан минь бий болж байнаа.

Эндээс эхлээд үр нь эндээ алдахгүйг хичээнээ

Эвлэж өгөхгүй онгодоо аргадаж байж бичив.

Ээждээ бичсэн шүлэг минь энд хүрээд өндөрлөв.

429 дүгээр хаалттай хорих анги-Төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг
Эрдэнэбат овогтой Хоригдол Цэлмэг

Ахуйнаас өвлөсөн бидний бахархал

/шүлэг/

Ээрч чарласан биднийгээ л тайвшруулах
Ээжийн минь хайрын намуухан бүүвэй
Морины сэрвээнд цогшин улалзах
Малч аавын минь лимбэн исгэрээ
Биднийг уянгалаг болгосон юм.
Өнгөрсөн бороонд туссан нарны
Өнгийн гэрлээр хацраа будаж
Ширхэглэх хуудастай муутуу цасанд
Шилбүүрийн үзүүрээр зураас таталсаар
Бид зураач болсон юм.
Нялх төлийн дуу нийлэн
Найралдан хорших эгшигт майлаан
Цэцэгтэй ширгийг сүлжин судалтах
Цэнхэр горхины хоржигнох боргио
Биднийг хөгжимлиг болгосон юм.
Айраг барлах намарших цагаар
Айл саахалтаараа найрлан дэмбээдээд
Билэгт цэцэн ерөөл талбин
Баатарлаг эх туульс хайлсандаа
Бид найрагч байдаг юм.
Үсчсэн айргаар нойроон сэргээн
Үүрийн харанхуйгаар адуундаа мордон
Босоо төрсөн гуурст хангалыг
Булгих цалгианд нь тонгорч унагасаар
Бид эрдүү болсон юм.
Нар зөвөөр үйлээ тойруулж
Нанчид хүртэхдээ ч насаар эрэмбэлэн
Ахмад хүмүүний үгэнд ухаажиж
Ашдын сайнаар мялаалгасан болохоор
Бид сургаалтай байдаг юм
Овооны чулууг ч шуух хүндлэлтэй
Онгон байгалиа ч хайрлах сэтгэлтэй
Эртний бичгээ ч гээгээгүй соёлтой
Эрлэгээс ч харамлах нутагтайдаа
Бид эх оронч байдаг юм.

435 дугаар хаалттай хорих анги
Лхагвасүрэн овогтой хоригдол Оюун-Эрдэнэ

ЯРИЛЦЛАГА ХИЙСЭН ТЭМДЭГЛЭЛ

Хөвсгөл аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын сэтгэл зүйч, ахмад А.Сайнтуяагийн, хоригдол Ч.Г-тэй хийсэн ярилцлагын тэмдэглэлээс...

-Сайхан амарсан уу? Өглөөг яаж угтав даа?

-Сайхан та сайхан амарсан уу? Энэ өглөөг их догдлолтой угтлаа. Хүүхдүүдээ бодохоор дотор нэг зүйл товойгоод байгаа ч юм шиг, гүнзгий амьсгал аваад өөртөө тайван байгаарай гэж хэлээд л бослоо. Энд байх хугацаандаа цаг хугацаа ямар их үнэ цэнэтэйг илүү их ухаарч байна. Ээж, хүүхдүүд, эгч дүү нартаа очно гэж бодохоор сэтгэл догдлоод их сайхан байна.

-Удахгүй эх, үрсийн баяр болох гэж байна. Энэ баяраар хүүхдүүдээ баярлуулж байсан сэтгэлд тод үлдсэн дурсамжаа хуваалцаж болох уу?

-Нэлээд хэдэн жилийн өмнө хоёр хүүгээ Улаанбаатар хотод баярлуулахаар явж байсан юм. Гэтэл хотын гудамжаар явж байгаад гэнэт хоёр хүүхэд маань байдаггүй алга болчихдог байгаа. Бид 2 чинь сандраад тэр хавиараа жаал хайж гүйгээд...

Тэгсэн манай хоёр хүүхэд нэг байрны гадаа байдаг хүүхдийн тоглоомын талбайд тоглож байсан. Бид хоёр ч бөөн баяр, хоёр хүүхдээ тэр талбайд нь хэсэг тоглуулж байгаад авч яваад хүүхдийн паркад очиж хүссэн тоглоомон дээр нь тоглуулж байсан юм. Тэр үеийн хүүхдийн баяр тэмдэглэсэн маань санаанаас ер гардаггүй айдас, баяр, хөөр зэрэгцсэн их сайхан баяр болж билээ.

Тэгэхэд би хоёр хүүхэдтэй байсан, одоо бол гурван хүүхэдтэй болсон. Бага хүү 6 настай, энэ жил сургуульд орно. Хүүгээ сургуульд нь хүргэж өгнө гэж бодохоор сэтгэл догдлоод байна.

-Гурван хүүхдийн эцэг байна гэдэг үр хүүхдээ эрүүл зөв Монгол хүн болгон өсгөн хүмүүжүүлэх өндөр хариуцлага бас эцэг хүний хүндлэл хайр чамайг хүлээж байгаа юм байна. Цаашдын зорилгынхоо талаар яриач?

-Эхний ээлжинд хүүхдүүдээ өөр дээрээ авах бэлтгэл хийж, гэр орноо сайхан тохижуулж төвхнүүлнэ. Хоригдож байх хугацаандаа нэлээд зүйлийг сурсан. Барилгын засал чимэглэл, замаска татах, өнгө будаг гаргах болон гар оёдол хийх гээд өөрийнхөө юу хийж сурсанаа хүүхдүүддээ, ээждээ харуулж, аав нь цагийг дэмий өнгөрүүлээгүй гэдгийг ойлгуулна.

Хүмүүс хорих байгууллага гэхээр айдаст автсан, муухай газар гэж ойлгоод байдаг. Би ч гэсэн тэдний нэгэн адил тэгж бодож явсан. Харин одоо арай өөр бодолтой болсон. Хорих байгууллага чинь хүнийг хүмүүжүүлэх, зааж сургах зөв амьдрахад нь тусалж дэмждэг байгууллага юм байна. Хэдий би амьдралд алдсан ч хорих ял эдэлж байхдаа ихийг ойлгож ухаарсан бас сурсан.

Хэрэв би ял эдлээгүй байсан бол амьдралд зөндөө алдах байсан гэж одоо бодож суудаг. Би юмыг өнгөц харж дүгнэдэг, амархан уурладаг, хэн нэгэнд дандаа гомдоллож явдаг зан маань одоо ард үлдсэн.

Би суллагдан гараад салсан эхнэрээсээ уучлалт гуйна. Өмнө нь би хорсол тээн гомдож явдаг байжээ. Одоо бол би ч бас буруутай байсан юм байна гэдгийг ойлгох болсон. Тийм ч учраас тэрнээсээ уучлалт гуйж буруугаа хүлээж, түүндээ амьдралд нь сайн сайхныг хүсэн ерөөнө.

Хүнийг уучилна гэдэг нь өөрийнхөө сэтгэл санааг тайвшруулж цаашид сайхан амьдрах, урагшаа харж алхахад тус дэм өгдөг агуу үйл гэдгийг ойлгосон. Болдог бол би бүх хүмүүст бие биенийгээ уучилж, хүлээцтэй, тэвчээртэй байгаарай гэж хэлмээр байна.

-Нээлттэй бодол санаагаа хуваалцаж ярилцсанд баярлалаа. Сайн сайхныг хүсэж ярилцлагыг өндөрлүүлээ.

"ЗАРЛАН МЭДЭЭЛЭХ ТӨХӨӨРӨМЖ"-ИЙГ ҮЙЛ АЖИЛЛАГААНДАА НЭВТРҮҮЛЛЭЭ

409 дүгээр хаалттай хорих анги нь 2015 оноос "Зарлан мэдээлэх төхөөрөмж"-ийг хоригдлын нэгдсэн тоо болон сургалт, хүмүүжлийн ажилд ашиглаж, 2018 онд шинэ байранд орсонтой холбогдуулан уг үйл ажиллагаа нь түр зогссон байсныг боловсронгуй болгож өдөр тутмын үйл ажиллагаандаа 2020 оны 06 дугаар сарын 10-ны өдрөөс ашиглаж эхэллээ.

"Зарлан мэдээлэх төхөөрөмж"-ийг хорих ангийн дотоод цагийн хуваарийн дагуу 06:50 цагаас орой 22:00 цаг хүртэлх хугацаанд хоригдлыг нэгдсэн үйл ажиллагаанд хамруулахад ашиглаж байгаа ба мэдээлэл бүрийн өмнө бүрээ, ая эгшиглэж дараах байдлаар зарлаж байна. Тухайлбал:

1. 06.50 цагт бүрээ 20 сек дуугарч Улаанбаатарт 07 цаг болж байна гэж зарласны дараа төрийн дуулал эгшиглэж өглөөний босолт болсоныг зарлана.
2. Салхилгааны цаг болсон бол нийт хүмүүжигч салхилгаанд гарна уу
3. Хөдөлгөөнт дасгал хийх цаг болсон бол нийт хүмүүжигчид хөдөлгөөнд дасгалаа хийнэ үү
4. Нэгдсэн бүртгэлийн цаг болсон бол нийт хүмүүжигчид нэгдсэн бүртгэлдээ хамрагдана уу гэж мэтээр цагийн хуваарьт үйл ажиллагааг зарлан мэдээлж байна.

"Зарлан мэдээлэх төхөөрөмж"-ийг ашигласнаар хоригдол хорих ангийн дотоод цагийн хуваарийн дагуу нэгдсэн үйл ажиллагаанд хамрагдах, алба хаагч, хоригдол хоорондын харилцаанаас үүсэх зөрчлийг бууруулах, урьдчилан сэргийлэх, тэднийг цаг үеийн мэдээ мэдээллээр хангах, сургалт, хүмүүжлийн ажлыг зайн хэлбэрээр зохион байгуулж байгаа нь ач холбогдолтой ажил болсон байна.



СПОРТЫН МЭДЛЭГТ



Спорт хүмүүст оюун санаа болоод бие махбодын тэсвэр тэвчээр, тэмцэх чадварыг бий болгодог. Спортоор байнга хичээллэдэг хүмүүс цаанаасаа л нэг энергитэй эрч хүчтэй дайчин чанартай байдаг. Энэ нь ч тэднийг амжилтад хүргэх гол түлхүүр болдог.

ДЭЛХИЙН АЛДАРТАЙ СПОРТЫН ТӨРЛӨӨД



Сагсан бөмбөг

Анх сагсан бөмбөг хүмүүсийг биеийн тамирын хөдөлгөөнд оруулах зорилготой үүсэж байжээ. Доктор, Жэмис Найсмит 1891 онд залуу тамирчдыг өвлийн улиралд хэрхэн үр бүтээлтэй өнгөрөөх вэ гэсэн санаанаас сагсан бөмбөг анх мэндэлжээ. Тэрээр анх сагсан бөмбөгт зориулж 13 дүрэм зохион мөрдөж байсан. Ингээд ангийн хүүхдүүдийг 9 хүнтэй багт хувааж хөл бөмбөгийн бөмбөгөөр тоглуулжээ. Анхны сагсан бөмбөгийн тэмцээн 1892 онд Масачусетсэд болж байв. Үүнээс хойш 1936 онд сагсан бөмбөгийг Олимпын тоглолтод оруулахаар болжээ.

Хөлбөмбөг



Хөлбөмбөгийн эргэн тойронд нэг зүйл их ойлгомжгүй байдаг. Дэлхий даяараа хөлбөмбөгийг Football гэж мэдэж байхад Америкчууд Soccer гэдэг вэ? Учир нь Америкт football гэдэг спорт аль хэдийн мэндэлчихсэн байсантай холбоотой юм.

Мөн Англид хөлбөмбөгийг Soccer гэж дуудсаар байсан юм. 19-р зууны сүүл гэхэд хүн төрөлхтөн бөмбөгтэй холбоотой нэлээн олон төрлийн спортоор тоглоод эхэлчихсэн байсан. 1863 онд анх хөлбөмбөгийн холбоо байгуулагдан бүх дүрэм стандартуудыг тодорхой болгосноор хөлбөмбөг мэндэлжээ. Хөлбөмбөгийн нэр хүнд өсөөд олон оронд Football гэж дуудах

болсноор Англид ч гэсэн Football гэж дуудаж эхэлсэн байна.

Хөлбөмбөгтэй төстэй зүйл тоглож байсан түүхийг сөхвөл маш эртнийх. Христийн тооллын өмнөх 1000 онд Европт тоглож байсан ул мөр олдсон байдаг.

Хөлбөмбөг Европт тоглохыг хориглож байсан түүх бий. Эдвард IV болон Эдвард II, Оливер Кромвелл гэсэн хаад Английн эзэмшил нутагт тоглохыг хориглож байв. Тэр үед гахайн давсгийг хийлж эсвэл дотор нь юм хийж тоглодог байжээ.

Хоккей

Түүхийг сөхөж үзвэл 1600 оны үед Герман хүмүүс мөсөн дээр хоккейтэй адил спортоор тоглож байсан гэсэн байдаг. Мөн Америкийн хойд хэсгийн индианчууд мөсөн дээр хоккейтэй төстэй тоглоом тоглодог байсан гэсэн бичвэр олдсон байна.



Бидний мэдэх хоккей Канадын Нова Скотиагаас гаралтай. 1800 оны үед мөсөн дээр хүүхдүүд болон томчууд Хурлин гэдэг одоогийн хоккейтэй их төстэй спортоор тоглодог байжээ. Энэ нь явсаар 1875 оны үед мөсөн дээрх хоккей нэрийг авчээ.

Көөрлинг

Анх Роаринг Тоглоом нэртэй байжээ.



Учир нь мөсөн дээгүүр 18 кг жинтэй чулууг гулгуулах мөргөлдөх үед их хэмжээний чимээ гардаг байна. Үүссэн газар нь бол Шотланд юм. Эртний

олдвороос харахад 1511 оны үед ч уг спортоор тоглож байсан баримт байдаг.

1830 онд АНУ-д хүрснээр маш хурдтай түгэн дэлгэрчээ. Өнөөдрийн байдлаар Канадчуудын 90% энэ спортоор тоглодог гэсэн судалгаа байдаг.


Бейсбол

Эртний Грект 2000 жилийн өмнө



тоглож байсан гэсэн баримт байдаг. Одоогийн спортын хэв маягийг Европт олж АНУ-д цэцэглэн хөгжжээ. Мөн эртний Францад 1330 онд тоглож байсан гэж байдаг. Албан ёсоор бүртгэгдэн спорт болсон нь АНУ-д 1791 онд Масачусетс мужийн Питтсфилдэд анх дүрэм журамтай тоглож эхэлсэн явдал юм. Ер нь 18-р зууны үед Америкийн зүүн эрэг дээр их олон спортууд жинхэнэ утгаараа хөгжиж эхэлсэн байдаг.

Бокс



Эртний Месопетамиянд 7000 жилийн өмнө анх бокс тоглож эхэлсэн байна. Грек болон Ромын үед илүү харгис тулаан зохион байгуулдаг байжээ. Манай эриний өмнөх 688 онд Олимпын тэмцээнд нэгдсэн байна. Түүхийн явцад энэ спорт нь бага зэрэг баларсан ч 17-р зууны Англид дахин хүчээ авч эхэлсэн. Түүхэнд бичсэнээр 1684 онд Жэмис Фиг гэж залуу Английн анхны боксын аварга болж байв. Тэрээр амьдралынхаа турш ганцхан удаа л ялагдал хүлээж байсан гэдэг. Анхны боксын дүрмийг 1743 онд батлан илүү

аюулгүй сонирхолтой болгожээ.

Газрын теннис

Теннисний тухай баримт эртний



Египет болон Грект их байдаг ч хамгийн баттай нь 10-р зууны үед Францад үүссэн гэсэн түүхийн баримт юм. 13-р зууны үед Францад хамгийн их эрчээ аван хот даяар 1800 теннист зориулсан талбай зассан байлаа. Одоогийн бөмбөг бий болохоос өмнө ороосон утас болон арьсаар тоглодог байжээ.

1850 онд Чарлес Гүүдьяр анхны боловсруулсан резинийг бүтээснээр теннисний хөгжлийг шинэ шатанд гаргажээ. 1874 онд Маяор Валтер С. Вингфиелд анхны дүрэм журмыг бий болгосноор теннис дэлхий даяар хөгжиж эхэлжээ. Анхны тэмцээн 1877 онд болсон. Эмэгтэйчүүд 1884 оноос тоглож эхэлсэн байна.

Гольф



Манай эриний өмнөх 100 оны үед Ром болон Хятадад тоглож байсан түүхийн үлдэгдэл байдаг. Европын олон оронд гольфтой төстэй спортууд дэлгэрч байв. Одоогийн Гольф нэрийг Шотландын goff буюу цохих гэсэн үгнээс гаралтай гэж үздэг. 1744 онд Эдинбургт 13 дүрэмтэйгээр анхны нүхийг хийж тэмцээн зохиож эхэлсэн. Одоог хүртэл энэ дүрэм хүчинтэй хэвээр байна.

Эх сурвалж Bro.mn сайт

ТҮҮХИЙН МЭДЛЭГТ



МЭНДЛЭХ, ХҮНДЛЭХ МОНГОЛ ЁС

Монголчууд бид аж төрөх, айл гэрийн ёсны баялаг уламжлалтай. Мэндлэн хүндлэх, зочлох ёсон, хүүхдийн нэр өгөх, хүүхдийн угаалгын зан үйл, хүүхдийн сэвлэг үргээх, удам залгуулах ухаан, найрын дэг ёс, шинэ гэрийн найр, хуримлах, насны ой тэмдэглэх, төл авахуулах, мал хөнгөлөх, ноос савах, эсгий хийх, ан агнуур зэрэг аж төрөх болоод айл гэрийн зан үйлийн гайхамшигтай ёс дэгтэй ард түмэн бид билээ.

Монголчуудын мэндлэх ёс гэж юу вэ?

Монголчуудын уламжлалт ёсонд насаар дүү хүн болон гаднаас ирж буй зочин эхэлж мэнд амар айлтгадаг. Монголчуудын мэндлэх ёс нь жилийн дөрвөн улиралд зохицсон байхын хамт уулзсан хүнийг хийж буй ажил үйлсийг ерөөх, талархаж мэндлэх, улмаар амар амгаланг айлтгадаг байна.

Үүнд:

Зуны улиралд Сайхан зуншиж (зусч) байна уу? Мал тарга авч байна уу?

Ногоо цагаа элбэг үү?

Намрын улиралд: Тарган сайхан намаржиж байна уу? Мал сүрэг тарга сайн авав уу?

Сөл ногоо сайн уу?

Өвлийн улиралд: Өнтэй тарган, өвөлжөөгөөр сайн байна уу?

Зутрахгүй мэнд байна уу?

Хаврын улиралд: Сайхан хаваржиж байна уу?

Өвөлдөө мал сүрэг тарган оров уу? Төл мэнд, сүрэг өсч байна уу? гэх мэтээр цаг улирал харгалзан мэндчилэх үгс нь монголчуудын эрхлэн адгуулж ирсэн мал сүрэг, аж ахуй өөдрөг байхыг эрхэмлэн дээдлэхийн билэгдэлтэй үргэлж холбоотой байсан ажээ.

Мөн хүний үйлдэн бүтээж буй хөдөлмөрийг ерөөж мэндчилэх ёс их

өргөн уламжлагджээ. Жишээлбэл, унгас ноос савж буй хүмүүстэй мэндлэхдээ: - Саваа чинь шандас Савсан ноос чинь мяндас болох болтугай! гэж ерөөн мэндлэхэд: - Тэр билэг бат сайхан орших болтугай! гэж ерөөлийг хүлээн авснаа илэрхийлэн хариу талархдаг байна.

Сааль сааж байх үед: - Хонь сүүтэй болог! - Саасан сав дүүрэг! Оёдол үйл хийж буй хүнд: - Үйл бүт! Үйл уран болог!

Эсгий хийж байх үед ирсэн хүн: - Дун шиг цагаан Дурдан шиг артай болох болтугай! - Бухын дух шиг бужийж, - Азарганы сайр шиг Арзайж байх болтугай! хэмээн ажил үйлсийг нь ерөөдөг ажээ.

Эдгээр ерөөлийг хүлээн авч хариуд нь: - Тэр ерөөл бат орших болтугай! Ерөөл шингэж байг (байтугай) гэх зэргээр хариу билэгддэг байв.

Мөн хурдан морь сойж буй

уяачидтай мэндлэхдээ: - Агт сайхан агсарч байна уу? - Морь сайхан давхиж байна уу? - Морь хурдалж байна уу? гэж ажил үйлсийн утгаар мэндэлдэг ардын уламжлал бий.

Халхчуудын мэндчилгээний ёсонд хээр тал, аян жин, нүүдэлд яваа үест зориуд зам тосон уулзаж, мэндчилдэг заншил элбэг байв.

Тухайлбал, хонь хариулж яваа хүнтэй уулзахдаа: - Хонин сүрэг сайхан тогтож байна уу? хэмээдэг бол үдэш хонины хүн ирэхэд: -Хонь сайн хариулж, мал сайн тогтов уу? гэж асуун угтдаг.

Аян жинчид зам зуурт тааралдвал зөв талаараа зөрцгөөн, - Аян замдаа сайн явж байна уу? нутаг хошуу хаагуур вэ? гэх зэргээр хүндэтгэлтэй мэндлэн өнгөрдөг ёстой.

Мөн "Ая зан юутай вэ?", "Хэрэг зориг бүтэмжтэй юу?" гэж найрсаг дотноор, ажил явдлын сэтгэлээр мэндчилнэ.

УЛААНБААТАР ХОТЫН ТҮҮХ

Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын түүх бол Монголчуудын эрх чөлөө, тусгаар тогтнолын төлөө тэмцэл, тусгаар тогтносон орны улс төр, эдийн засаг, шашин, соёлын төвийн түүх, Монголчуудын бэлгэдэл юм.

* Улаанбаатарын үндэс суурь Хүрээ буюу Өргөөний тухай түүхэн сударч 1649 оноос тэмдэглэж эхэлсэн байдаг.

* Нүүдэлч удмын их төвлөрөл Алтан тэвшийн хөндийд суурьшталаа хориод удаа нүүдэллэж 1778 онд Туулын хөндийд төвхнөсөн гэдэг.

* 1926 онд Ардын цэнгэлдэх хүрээлэн буюу Бөмбөгөр ногоон сүндэрлэсэн нь Улаанбаатар хотыг чимсэн хамгийн том барилга байгууламж байжээ. Түүнээс өмнө одоогийн "Улаанбаатар" зочид буудлын хавьд хоёр давхар цувраа гурван байшин байсан нь Засгийн газар, Намын хороо, Эвлэлийн хороо байв.

* Энэ үед их хотын жолоо атгасан анхны дарга гучин хоёрхон настай Мононгийн Баяр байлаа. Сэцэн хан аймгийн Ачит бэйсийн хошуу /одоогийн Дорнод аймгийн Булган сум/-ны бичээч байсан залуу эр Цэргийн яаманд алба хааж, Хатанбаатар Магсаржавтай хамт нэг өдөр МАХН-д элссэнийг үзэхүл их Ц.Нацагдоржтой бие тусдаа ч, янтай нэг явсан байж мэдэх л юм. Юутай ч хотын төр захиргааны дүрэм батлуулж, хотын түр захиргааны дарга 1, жинхэнэ бичээч 2, ажилчин 11, морьтой зарлага 2, гишүүн 3, нарийн бичгийн дарга 1, бүгд 20 орон тоотой батлуулан ажлаа эхэлжээ.

Монгол Улсын нийслэлийн нэр түүхэндээ таван удаа солигдож байжээ.

Өргөө

/1639-1651 он/

1639 онд одоогийн Өвөрхангай аймгийн Бүрд сумын нутагт Цагаан нуур буюу Ширээт нуур гэдэг газар шашны тэргүүнээр Занабазарыг өргөмжлөхдөө түүнд зориулж Орд-Өргөөг байгуулж өгчээ. Энэ өргөө нь өнөөгийн Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын үүсэл болсон гэж үздэг.

Өргөө нь: Монголын шарын шашны төв-Халх Монголын улс төрийн төв-Гадаад дотоодын худалдааны чухал зангилаа голомт болж байсан байна. Өөрөөр хэлбэл, Өргөө нь жинхэнэ хот болон хувирах хөгжлийн шинэ үедээ орсон байна.

Номын хүрээ

/1651-1706 он/

Өргөө нэрээр анх ханаа дугуйлсан нийслэл хотын анхны нэр Номын хүрээ болон өөрчлөгджээ.

Их хүрээ

/1706-1911 он/

Энэ үеийн гол онцлог нь Их хүрээ суурьшиж хот болон хөгжиж эхэлсэн явдал юм. Их хүрээ 1706-1911 онд одоогийн Улаанбаатар хотын төв хэсэг байгаа Сэлбийн голын хөндийд бууснаас хойш суурьшиж эхэлсэн гэдэг. Монголын урчууд сүм дуганыг барьж байгуулахдаа үндэснийхээ барилга ялангуяа гэрийн уламжлалыг чадамгай ашиглан хөгжүүлсний зэрэгцээ Хятад, Төвд уран барилгын уламжлалаас хэрэглэж байжээ.

XIX зууны үед Их хүрээ зөвхөн шашны төв төдийгүй Монгол орны улс төр, засаг захиргаа, соёлын чухал төв, худалдаа харилцааны том зангилаа болж жинхэнэ хот болон хувирсан. Энэ үед Их хүрээний нийт хүн ам 15-20 мянга орчим байсан боловч уу гэж үздэг. Их хүрээ хотод Гандан, Зүүн хүрээ, Баруун дамнуурчин, Маймаа хот, Консул сайдын яам, Дамбадаржаа зэрэг газрууд хамаарагдаж байсан байна. Их хүрээ нь XIX зууны эцэс гэхэд Монгол орны шашин, улс төр, худалдаа, үндэсний болон нийгмийн зөрчил тэмцлийн гол зангилаа төв болж чадсан юм.



Нийслэл хүрээ

/1912-1921 он/

Сэргээн байгуулагдсан Монгол улсын нийслэл болсон үе. Нийслэл хүрээ улс орны амьдралд онцгой үүрэг гүйцэтгэх болсон.

Улаанбаатар хот

/1924 оноос одоо хүртэл/

1924 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн 14 дүгээр хуралдаанаар нийслэл хотыг улсын нийслэл хот гэдгийг давтан хуульчилж хотын нэрийг Улаанбаатар хот хэмээн өөрчлөхөөр болсон.

1954 онд анх удаа Улаанбаатар хотыг хөгжүүлэх 20 жилийн хэтийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулж хэрэгжүүлж эхэлсэн.

1990-ээд оны зун Монголд анх удаа олон намын оролцоотой ардчилсан сонгууль явагдсан. Энэ сонгуулийн үр дүнд Монголд анхны байнгын ажиллагаатай, олон намын бүрэлдэхүүнтэй парламент Улсын бага хурал байгуулагдсан.

1992 онд Монгол Улсын шинэ Үндсэн хууль (4 дэх) батлагдсан. Монгол улсын Үндсэн хуулинд "Монгол Улсын нийслэл нь Улаанбаатар хот мөн" гэж заасан юм. Нийслэл нь өөрийн туг, бэлгэ тэмдэгтэй.



ТАНЫ МЭДЛЭГТ



АНГЛИ ХЭЛНИЙ ХИЧЭЭЛ

АНГЛИ ХЭЛНИЙ АВИА ЗҮЙН ТАЛААР
SSIAN, SSION, TION, CIAN, CIAL, TIAL

SSIAN, SSION, TION, CIAN, CIAL, TIAL нийлэмжгүй өргөлтгүй үед [ʃən] буюу [ʃn] /шэн/ гэж дуудагдана.
Session –[seʃn], Russian–[ruʃn], translation – [trænsleɪʃn], physician – [fɪzɪʃn] CIAL, TIAL
Нийлэмжүүд өргөлтгүй үед [[ʃən] буюу [ʃɪ] гэж дуудагдана.
Special – [speʃl], essential – [ɪsenʃl]/шэл/

Бусад нийлэмж үсгүүдийн дуудлага

ANGE [eɪndʒ] өргөлттэй үед ингэж дуудагдана.
Change[tʃeɪndʒ]
WAR[wɔ:] өргөлттэй үед ингэж дуудагдана.
Warm[wɔ:m]
SURE нийлэмж нь өргөлттэй үед [ʃuə] өргөлтгүй үед [z] гэж дуудагдана.
Sure[ʃu ə], measure[meəz] энэ нийлэмжийн өмнө орсон эа хос үсэг нь [e] гэж дуудагдана. Treas-

ure[treəz]
TURE, TURAL нийлэмжүүд нь [tʃə], [tʃərə] гэж түс түс дуудагдана. Lektüre – [lektʃə] Future – [fju:tʃə]

Балархай үсэг

Англи хэлний цөөн хэдэн үсэг нь дараах тохиолдлуудад дуудагдаггүй байна.
E-г үгийн эцэст нэг эгшгийн дараа file [faɪl]
W-г үгийн өмнө write-[raɪt]
K-н үгийн өмнө knee-[ni:]
B-t үгийн өмнө debt-[det]
B-m үгийн дараа bomb-[b :m]
GH –үгийн эцэст заримдаа дунд higt-[haɪ]
Gh- үгийн өмнө gnaw-[n:]
Who үгийн өмнө [h] whole-[houl] бусад үед [w] why[wai]

Дагаваруудыг дуудах байдал
ҮЙЛ ҮГИЙН ДАГАВАР –ED

- Эс тухайлах өнгөрсөн цаг нөхцөл үйл үгийн өнгөрсөн цагийн дагавар
1. дуугүй ба шуугиант гийгүүлэгчдийн дараа [f]
2. d,t- гийгүүлэгчийн дараа[ɪd]
3. у-үсэг l-ээр солигдсон[ɪd]

4. бусад тохиолдолд[d]

ҮЙЛ ҮГИЙН ДАГАВАР S,ES

- Эс тухайлах одоо цагт байгаа үйл үгийн дагавар
1. Дуугүй ба шуугиант гийгүүлэгчийн дараа [s]
2. Бусад тохиолдолд[z]
3. O-г эгшгийн дараа (O+ES залгадаг).....[z]
4. Бусад тохиолдолд (SS, SH, CH,TCH, X+ES),....[z]

Нэр үгийн олон тооны дагавар

1. p, t, k- ийн дараа[s]
2. бусад эгшиг гийгүүлэгчийн дараа[z]
3. бүх тохиолдолд[ɪz]

Нэр үгийн хамаатуулах дагавар

1. нэр үгийн ард (')-орхиос, S- дагаварыг шууд залгана.
2. нэр үг нь S- үсгээр төгссөн бол (') орхиос залгана. Ж нь: studen's-оюутны , students-оюутнуудын

Ялгац гишүүн, сул үгийг дуудах a, an, the, to

1. эгшгээр эхэлсэн үгийн өмнө [aən]
[] [tu:]
2. гийгүүлэгчээр эхэлсэн үгийн өмнө[əə] [] [tə]

Гийгүүлэгч үсгүүд

Гийгүүлэгч үсгийг хэлэхэд дуу анир хоёрын аль голлон хэрэглэгдэж байгаагаар нь чанга аниртай дуутай гийгүүлэгч гэж ангилдаг. Жишээ нь: Монгол хэлний “Я” туслах эгшиг нь “j+a” гэж анир дуу хоёроос бүтсэн байдаг бөгөөд аль нэг нь голлоогүй байдаг.
Англи хэлний гийгүүлэгч: B,C,F,G,H,K,L,M,N,P,Q,R,S,T,V,Y,W,X,Z, хагас гийгүүлэгч J
Гийгүүлэгч үсгийн дуудлага: /p,b,t,d,k,g,m,n,,l,w,f,v,,,s,z,,,j,,,/
Чанга аниртай дуугүй: P,T,K,Z.....z.
Шуугиант: S....., Хамрын: M,N.....m, Хажуугийн: L.....l



ГАГНУУР ХИЙХ ҮЕИЙН АЮУЛГҮЙ АЖИЛЛАГАА

ЦАХИЛГААН ГАГНУУРЫН АЖИЛД ТАВИГДАХ ШААРДЛАГА

- Гагнуурчин нь аюулгүй ажиллах арга барилыг эзэмшсэн, мэргэжлийн байх;
- Ажлын хувцас бие хамгаалах хамгаалах хэрэгсэл /бризентэн, элгэн өмд, цамц, малгай, бээлий/ бүрэн өмссөн байх;
- Гагнуурын аппаратыг цахилгааны самбарт залгахдаа ашиглалтын зааварт заасан утсаар холбож ажиллуулах;
- Гагнуурын аппаратыг засварлахажлыг мэргэжлийн цахилгаанчин, засварчнаар хийлгэх;
- Гагнуурын аппаратын их биеийн газардуулгагүй, тэжээлийн утас шалбарч гэмтсэн, ашиглалтын зааварт заасан шаардлагыг хангаагүй тохиолдолд ажиллахгүй байх;
- Нойтон чийгтэй, хальтиргаатай газарт хамгаалалтын хэрэгсэл, тоноглолгүйгээр ажиллахгүй байх;
- Гагнуурчин гагнаж байгаа зүйл, гагнуурын аппаратын газардуулгыг ажлын дундуур шалгаж байх;
- Ажил дууссаны дараа гагнуурын аппаратыг цахилгаан хүчдлээс салгах;

ХОРИГЛОНО.

- Цахилгаан тэжээлийг зориулалтын бусаар залгасан үед гагнуур хийх,
- Технологийн тоног төхөөрөмж, ус түгээгүүрийн шугам, бохир усны шугамыг Газардуулагчийн зохиулалтаар хэрэглэх,
- Хамгаалах баггүй ажиллах
- Гагнуурын аппаратыг цахилгаан шугаманд залгахдаа 500В-оос дээш хүчдэлд залгах
- Гагнуур хийхдээ өөр зүйлд анхааралаа хандуулах, бусадтай ярилцах
- Гагнуур хийхдээ салхивчийг ажиллуулах, хаалга, цонхыг нэвт салхилуулах



Гагнуурын ажлыг өндөрт гүйцэтгэх



Цас, бороотой үед гагнуурын ажлыг заавал саравчны дээр гүйцэтгэх

